



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 01-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-41
1.“Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/	8-12
2.“Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/	12-13
3.“Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/	13-14
4.“Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/	14
5.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	14-34
6.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	34-43

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 01-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 58 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Н.Наранбаатар, Д.Цогтбаатар;
Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, Н.Номтойбаяр, Ө.Шижир,
Л.Энхнасан, Р.Эрдэнэбүрэн.

Нэг. “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Г.Тэмүүлэн: “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	7
Бүгд:	16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Гадаад харилцааны сайд

Б.Батцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар

ТОГТОВ.

Уг асуудлыг 14 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, мөн штабын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Бүрэнтөгс, Гадаад харилцааны яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн хэлтсийн шинжээч Ч.Цацрал, ахлах мэргэжилтэн Б.Сувд, Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Б.Лхагвацэнд, ахлах аудитор Ж.Нямцэцэг, П.Батцэцэг, Д.Цэгмиддорж, Б.Ариунжаргал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, С.Эрдэнэболд, Ч.Анар, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Г.Хосбаяр нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар

ТОГТОВ.

Уг асуудлыг 15 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Анар, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Н.Уранцэцэг, Б.Дэнсмаа, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч Т.Хонгор, мөн хэлтсийн мэргэжилтэн Р.Хангал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, мөн яамны Америк, Ойрхи Дорнод, Далайн орнуудын захирал А.Ананд, Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, мөн штабын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Бүрэнтөгс, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Б.Лхагвацэнд, ахлах аудитор Ж.Нямцэцэг, П.Батцэцэг, Д.Цэгмиддорж, Б.Ариунжаргал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, С.Эрдэнэболд, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 50 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг” танхим 13 цаг 58 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажикбэрийн Жангабыл гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр 2025 оны 7 сарын 1-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Барбадос улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газар 6 сарын 27-нд өргөн мэдүүлсэн.

Хоёрдугаарт, Эсватины хаант улстай дипломат харилцаа тогтоох тухай,

Гуравдугаарт, Бүгд найрамдах Тринидад ба Тобаго улстай дипломат харилцаа тогтоох тухай,

Дөрөвдүгээрт, Бүгд найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай Засгийн газар 6 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн 4 асуудал байна.

Тавдугаарт, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 2 дахь хэлэлцүүлэг байгаа. Санал, дүгнэлтээ манай Байнгын хорооноос Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэх ийм дэгтэй байна.

Зургаадугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд байна. Мөн 2 дугаар хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлэхээр байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёё. Ажлын хэсгийг оруулаарай.

Гадаад хэргийн яам. Барбадос устай Дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Гадаад харилцааны сайд Батцэцэг сайд хүрэлцэн ирсэн байна. ГХЯ-ны Бодлогын газрын захирал Бямбасүрэн. мөн тус яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Соёлмаа захирал хүрэлцэн ирсэн байна аа.

Ингээд Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батцэцэг сайд танилцуулна аа. Таныг микрофонд урьж байна.

Б.Батцэцэг: Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Тэмүүлэн таньд, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэслэн НҮБ-ын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох шийдвэрийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2013 онд гаргасан.

Энэхүү шийдвэрийн мөрөөр ажилласны дүнд өнгөрсөн хугацаанд Эсватины хаант улс, Барбадос улс, Бүгд найрамдах Тринидад ба Табаго Улс мөн хамгийн сүүлд Бүгд найрамдах Ботсвана Улстай тус тус дипломат харилцаа тогтоох тухай хамтарсан албан мэдээнд гарын үсэг зураад байна.

Манай дотоодын хууль тогтоомжийн дагуу улс тус бүр дээр дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоол батлуулах шаардлагатай. Ингэснээр манай улсын НҮБ-ын гишүүн бүх 192 улстай дипломат харилцаа тогтоох зорилт бүрэн хэрэгжиж байгаа юм.

НҮБ-ын бүх гишүүн улстай дипломат харилцаа тогтоосон улс орон цөөн байдаг бөгөөд энэ нь манай улсын идэвхтэй дипломат үйл ажиллагаа, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын чухал илэрхийлэл юм аа.

Монгол Улсын Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнд Улсын Их Хурлын бүрэлдэхүүн өргөжсөнөөс гадна шинэ бүтэц, бүрэлдэхүүнтэй Засгийн газар байгуулагдсан тул эдгээр дүрэм мөн улстай дипломат харилцаа тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлсний дүнд миний бие эдгээр тогтоолын төслийг 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурлын Хурлын даргад өргөн мэдүүлээд байна аа.

Иймд манай улс Эсватин, Барбадос, Тринидад Тобаго, Ботсвана улстай тус тус дипломат харилцаа тогтоох тухай тогтоолын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд хэлэлцүүлж батлуулах асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Батцэцэг сайдад.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя.

Эрдэнэболд гишүүнээр тасалъя. Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: Энэ чинь нөгөө улс улсаар 1, 1-ээр нь орж ирж байгаа юу тэ? Батцэцэг сайдад бас энэ дипломат харилцаа тогтоогоогүй НҮБ-ын гишүүн улсуудтай ээлж дараалан бас дипломат харилцаа тогтоох Монгол Улсын гадаад бодлогыг ингээд тэлэх үйл ажиллагааг бас ингэж амжилттай зохион байгуулж санаачилж байгаад бас талархал илэрхийлье.

Тэгээд энэ 21758 ам долларын GDP-тэй гэдэг чинь бас их сайн үзүүлэлттэй, тэгээд бас хүмүүс түгээмэл, сайн мэддэггүй парламентын засаглалтай ийм улс байна. Тэгэхээр ер нь яах вэ нөгөө яг энэ улстай яагаад дипломат харилцаа тогтоох гэж байгаа юм гэхээсээ гадна бас тухайн улсын талаар танилцуулга эд нарыг олон нийтээсээ мэдээлүүлэх зөв харагдаж байна. Тэгээд ер нь асуулт нь болохлоороо, цаашлаад ер нь ойрын зорилтод хэчнээн яг ийм дипломат харилцаа тогтоогоогүй НҮБ-ын гишүүн орнууд байгаа вэ? Одоогоор яг хэд албан ёсны тоо өнөөдөр 2025 оны 7 сарын 1-ний байдлаар хэд байгаа бөгөөд эдгээр Барбадос нь зэрэг 4 орон нэмэгдсэнээр хэд болох вэ? Цаана нь жишээлбэл ер нь шаардлагатай хэдэн улс байгаа вэ? Тэгээд ер нь том зургаараа энэ улсуудтай дипломат харилцаа тогтоох энэ ач холбогдол талаас нь та бас энэ нэгэнт энэ хурал хэвлэл мэдээллээр явж байгаа учраас олон нийтэд хандаж энэ талаар мэдээлэл өгөөч гэж хүсье.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Эрдэнэболд гишүүндээ баярлалаа. Манай Монгол Улс бас бид нар ер нь НҮБ-д 1961 онд элссэнээсээ хойш бүх улстай дипломат харилцаа тогтооё гэдэг зорилтыг тавьсан. Бүх улстай бид нар найрсаг сайхан харилцаатай байя. Бидний өөрийн улсын онцлог манай гадаад бодлогын үзэл баримтлал, аюулгүй байдлын үзэл баримтлал гээд олон баримт бичигт энэ бид нар бас зорилтынхоо хүрээнд бүх улстай дипломат харилцаа тогтооё гэдэг ийм эрмэлзэлтэй явсаар ирсэн.

Тэгээд НҮБ албан ёсоор бол 192 гишүүн оронтой, манайх өөрийгөө оруулах юм 193.

Тэгэхээр бид нар энэ саяын 4 улстай бусадтай нь бид нар байгуулчихсан байсан. Өөрөөр хэлбэл энэ саяын дурдсан 4 улстай байгуулснаар бүх улстай дипломат харилцаа тогтоож байгаа юм аа. Тэгэхээр НҮБ-ын 192 гишүүнтэй дипломат харилцаа тогтоочихсон улс орон бас тийм олон байдаггүй юм байна лээ.

Тэгэхээр манай энийг гадаад бодлогын бас нэг ололтоо гэж зүй ёсоор хэлж байгаа юм аа. Тэгээд таны саналыг бас хүлээж авлаа. Бид энэ 4 улсын талаар олон нийтэд бас энэ мэдээллийг бас дэлгэрэнгүй хүргэе ээ.

Г.Тэмүүлэн: Батцэцэг сайдад баярлалаа. Нэг зүйлийг зүгээр процедур юуны хувьд нэг тодруулаад асуучихмаар нэг зүйл гарсан нь яах вэ манай Аюулгүй байдлын байнгын хороо 2013 оны 4 дүгээр сарын 23-ыхаа хуралдааны шийдвэрийн дагуу ингээд бас нэг эдгээр 4 улстай дипломат харилцаа тогтоох тухай энэ шийдвэр гарч байсан. Энэний дагуу бас 2019 онд холбогдох эдгээр улсуудтай хамтарсан албан мэдээнд ингээд гарын үсэг зурсан байна гээд танилцуулга дээр орж ирсэн байгаад байгаа. Ингээд өнөөдөр бид нар бас Байнгын хоргоор хэлэлцээд энэ 7 хоногийн чуулганаар өргөн мэдүүлж ингэж батлуулснаар эдгээр улсуудаа дипломат харилцаа тогтоох тухай үндсэндээ манай улсын дотоодын процедур ингээд гүйцэтгэж байна гэж харж байгаа.

Тэгэхээр ер нь яах вэ 2019 оноос хойш яагаад зүгээр хамтарсан албан мэдээнд гарын үсэг зурснаас хойш ингэж цаг хугацаа алдсан байдаг юм. Цаад нөгөө талдаа хүндрэл учирсан ч гэдэг юм уу бид нараас ямар нэг хамааралтай асуудлууд үүссэн байдаг юм болов уу. Энэ дээр та бас нэг товч мэдээлэл өгөөч. Гишүүд бас сонирхож байж магадгүй.

Чуулган дээр бас гишүүд сонирхож магадгүй байх гэж бодож байна.

Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Түрүүн бас Эрдэнэболд гишүүний асуулттай ч гэсэн уялдаж байна. Яах вэ айлын талын процедур энэ 4 улсад бас нэлээн удаан явагдсан. Тэгээд эхний нэрлэсэн 3 улсаас гадна хамгийн сүүлд Барбадос улстай бид нар бас нэлээн биш Ботсванатай бас нэлээн удаж байж хамгийн сүүлд Ботсванатай өнгөрсөн жил захидал солилцоод яг албан ёсоор тохирсон юм. Тэгээд бид нар энэ 4 улстай өнгөрсөн парламентын 2023 онд бид нар бас өргөн бариад тэгээд эцэслэж амжаагүй байж байгаад тэгээд Их Хурал солигдоод, Засгийн газар солигдоод 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлсэн юм.

Энэ дээр бол яах вэ тэгээд улс оронтой дипломат харилцаа тогтооно гэдэг зарим нь бараг 20, 30 жил ярилцаад явдаг тэгээд сүүлийн 4 жилийн хугацаанд бид нар 2013 оноос үндсэндээ энэ 4 улстай ярьж эхэлсэн. Тэгээд тэрнээс хойш процедурын хувьд 2 талтайгаа ойлголцох, уулзах, тэгээд нөхцөл байдлаа танилцуулах, бие биеийнхээ талаар судлах гээд бас нэлээн хугацаа зардаг. Тэгээд эцэст нь бол ингээд энэ 4 улстай тохирсон байгаа. Зүгээр сонирхуулахад хэлэхэд бид нар хэдэн орон гээд яг 192 оронтой дипломат харилцаа тогтоочихсон бэ гээд бас судлаад үзсэн. 192 орон дээр бас яг НҮБ-ын ажиглагч статустай Палистин, Ватикан гэж 2 улс байгаа. Энэ 2-той бас манайх дипломат харилцаа тогтоосон. Энэ ажиглагч статустай Палистин, Ватиканыг оруулах юм бол 194 болох юм. Оруулахгүй бол 192 юм шүү. Манайх шиг одоо ингээд 192 улстай дипломат харилцаа тогтоосон ийм 3 улс байна.

БНСУ НҮБ-ын 191 улстай дипломат харилцаа тогтоосон. Манайхаар нэгээр дутуу юм байна, тогтоосон. Үүнээс гадна ажиглагч Ватикан, Маккуори арлууд, Нью веттэй дипломат харилцаа тогтоосон байна.

Австралийн Холбооны Улс бас 191 улстай дипломат харилцаа тогтоосон байна. Австрали, Сири хоёр 1975 онд дипломат харилцаа тогтоосон боловч 2012 оноос хойш 2 улсын хоорондын дипломат харилцаа зогссон байна. БНАУ НҮБ-ын гишүүн 191 улстай дипломат харилцаатай бөгөөд үүнээс гадна НҮБ-ын ажиглагч

Ватикан түүнчлэн Косоватай дипломат харилцаа тогтоосон байна. Тэгэхээр манайх бол 192 оронтой дипломат харилцаа тогтоосон, мөн ажиглагч Палистин, Ватикантай дипломат харилцаа тогтоосон байна гэдгийг дахин хэлье ээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батцэцэг сайдад баярлалаа.

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Санал хураалт явуулна.

Санал хураалтад бэлтгэе.

Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Санал хураалтыг явуулъя.

Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг явуулъя.

Уг тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү.

Анхааралтай байгаарай. Санал хураалт.

56.3 хувиар дэмжигдлээ.

14.12 цаг

Дараагийн асуудалдаа орцгооё.

Санал дүгнэлтийг бас илтгэх гишүүнийг томилох ёстой байгаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүн Батсүмбэрэл гишүүн танилцуулъя.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл нэгдсэн хуралдаанд илтгэнэ ээ.

Хоёрдугаарх нь [Эсватини Хаант улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.](#)

Тус улстай Дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг мөн Батцэцэг сайд танилцуулна. Батцэцэг сайд таныг микрофонд урьж байна.

Б.Батцэцэг: Улс улсаар нь хэлэх үү? Эсватин улс. Эсватини Хаант улстай дипломат харилцаа тогтоох тухай тогтоолын төслийг дэмжиж өгөхийг хүсэж байна аа.

Г.Тэмүүлэн: Гишүүдэд танилцуулга мэдээллүүдийг бас тараагдсан байгаа. Цахимаар өгсөн мөн хэвлэлд тараагдсан байгаа.

Ингээд уг асуудалтай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэе хуруугаа уншуулцгаагаарай гишүүд.

Ингээд Эсватины Хаант улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг явуулъя.

Тус тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд саналаа өгнө үү?

Санал хураалт.

Гишүүддээ баярлалаа. 56.3 хувиар дэмжигдлээ.

Санал хураалтыг явуулж дууслаа.

Тус Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилъё. Манай Хосбаяр гишүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

Дараагийн асуудалдаа орцгооё.

Гурав дахь асуудал. [Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго улстай дипломат харилцаа тогтоогдох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлъё.](#)

Уг тогтоолын төслийн талаарх танилцуулгыг мөн Батцэцэг сайд бас танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

Б.Батцэцэг: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Тринида ба Тобаго улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж батлуулж өгөхийг хүсье ээ.

Г.Тэмүүлэн: Чуулган дээр та дэлгэрэнгүй уншина шүү. Сая Байнгын хорооны гишүүдэд тараагдсан учраас урьдчилан хүргүүлсэн байгаа учраас товч хураангуй явчихлаа. Тийм эхний асуудал дээр бас бүгдээрэнг нь уншаад танилцуулчихсан.

Асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүд байна уу? Эрдэнэболд гишүүн байсан уу? Алга байна. Санал хураалтад бэлтгэе. Хуруугаа уншуулаарай.

Ингээд Бүгд Найрамдах Тринидад Тобаго Улстай Дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү.

Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. 56.3 хувиар дэмжигдлээ.

Санал хураалтыг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр хэн танилцуулах вэ? Жангабыл гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

Ингээд 4 дэх асуудалдаа орцгооё.

14.17 цаг

Бүгд Найрамдах Ботсвана Улстай Дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Ингээд уг Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Батцэцэг сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

Б.Батцэцэг: Эрхэм байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улс Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай тогтоолын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулж өгөх асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Танд баярлалаа. Мөн танилцуулга материалууд тараагдсан байгаа. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалтад бэлдье. Хуруугаа уншуулаарай.

Ингээд санал хураалтыг явуулъя.

Ботсвана улстай Дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт 62.5 хувиар дэмжигдлээ.

Ингээд уг тогтоолын төслийг хэлэлцсэн санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Эрдэнэболд Жангабыл гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Өмнөх дээр нь бас буруу уншсан байна. Эрдэнэболд гишүүн Тринидад улстай дипломат харилцаа тогтоох тухай дүгнэлтийг танилцуулах юм байна. Уг асуудлыг хэлэлцэж дууслаа.

Тав дахь асуудалдаа орцгооё.

14.22 цаг

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг Байнгын хорооны танхимд оруулаарай.

Сангийн сайд байна уу? Монгол Улсын 2024 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2024 онд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Жавхлан сайд танилцуулна. Магнайсүрэн дарга орж ирсэн үү? Байна. Сангийн сайдыг орж ирж байтал Ерөнхий аудитор бас танилцуулгаа хийж байя.

2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн дарга танилцуулна аа. Таныг микрофонд урьж байна. 3 номер.

С.Магнайсүрэн: Байнгын хорооны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1.Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 57 тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 52 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 3 байгууллагад өөрчлөлтгүй, нэг байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 3.1 тэр тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоож 11 албан шаардлага, 1.9 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 12 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 22.6 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залрууллаа.

Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

Орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, Гадаад харилцааны сайд, Сангийн сайдын 2012 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн хамтарсан тушаалаар баталсан Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтнуудад олгох зардал, хангамжийн тухай журамд байр түрээслэх сургалтын төлбөр төлөх, суугаа орны Эрүүл мэндийн даатгалд даатгуулахтай холбоотой зохицуулалтыг тухайн орны онцлогт нийцүүлэн шинэчлэн боловсруулах.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 13.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 97.7 хувийн санхүүжилтийг олгожээ.

2.Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайланд 91 тайлан нэгтгэснээс 43 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 48 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 36 байгууллагад өөрчлөлтгүй, 7 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчил 18 төлбөрийн акт, 3 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсох 30 албан шаардлага, 3.3 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 166 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 6.7 тэрбум төгрөгийн 54 алдааг аудитын явцад залрууллаа.

Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Үүнд:

1.Батлан хамгаалахын сайдын харьяа байгууллагуудын газар эзэмших өмчлөх эрхийн бичгийг бүрэн гаргуулах, данс бүртгэлд тусгах,

2.Авлагыг хүчингүй болгосон Шүүхийн шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хасах, он удаан жил болсон авлагыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах эдгээр асуудал болно.

3.ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргын төсвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 3 тайлан нэгтгэснээс 1 байгууллагын санхүүгийн тайлан дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх нэг зөвлөмж өгч ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 69.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлант онд 55.8 тэрбум тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 6 төсөл арга хэмжээг 2024 онд шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Нийт төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 99.5 хувийн санхүүжилтийг олгожээ. Дээр дурдсан аудитын дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарал хандуулахыг санал болгож байна.

Үүнд:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоон хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ үнэлгээ хийж баталгаажуулах,

2.Засгийн газрын 2022 оны шинэ цэргийн анги байгуулах тогтоолын хүрээнд Зэвсэгт хүчний дугаар ангийн барилга байгууламжийн угсралтын ажил 2002 онд 1.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос хойш дахин санхүүжилт хийгдээгүйгээс барилгын ажил царцсан, хийгдсэн ажлын чанар байдал муудах болон анхны төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн.

Мөн 2024 онд шинээр баригдаж буй Зэвсэгт хүчний тусгай байгууламжийн барилга хугацаандаа баригдахгүй байх эрсдэл үүссэн байна.

3.Төсвийн ерөнхийлөн захирагчид худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах.

4.Аудитаар тогтоосон төлбөрийн акт өгсөн албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж алдаа зөрчил гаргахгүй байхад анхаарах зэрэг болно оо.

Танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Магнайсүрэн даргад баярлалаа.

Нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Засгийн газраас хийх ёстой байгаа. Сангийн яамнаас хүмүүс байна уу? Гараа өргөөрэй. ТНБД байгаа юу? Сайд ь байна уу? Сайдыг болоод, ТНБД орж иртэл Батцэцэг сайд та танилцуулгыг уншъя.

Монгол улсын 2024 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан сайд танилцуулна.

Таныг микрофонд урьж байна. Жавхлан сайд.

Жавхлан сайд.

Б.Жавхлан: Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаа анхны хэлэлцүүлэгт танилцуулсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 онд 29 их наяд 670 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр дүнгийн цэвэр зээлийн дүн 30 их наяд 591 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн 2 их наяд 451 төгрөгөөр төгрөгөөр сайжирч 920.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж ажиллалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах Гадаад харилцааны сайд, Батлан хамгаалахын сайд, ОБЕГ-ын нийт 69 байгууллагын төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 1 их наяд 82.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч үүнээс урсгал

зардал 912 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 170 тэрбум төгрөгөөр зарцуулсан байна аа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус Байнгын хороонд харьяалагдах 3 төсвийн ерөнхийлөн захирагчийн 19 төсөл арга хэмжээнд 91.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож гүйцэтгэл 86.4 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулга аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сангийн сайдад баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Сангийн сайд Жавхлан. Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Батлут, Монгол Улсын сайд, Гадаад харилцааны сайд Батцэцэг сайд.

БХЯ-аас БХЯ-ны ТНБД, Бригадын генерал Ганхуяг, БХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга хурандаа Оюунгэрэл, ЗХЖШ-ын дарга хошууч генерал Ганбямба, ЗХЖШ-ын Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга хурандаа Бүрэнтөгс, ГХЯ-аас Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Отгонцэцэг Сангийн яамнаас Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, тус яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, тус яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, тус яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, тус яамны Санхүүгийн зах зээл даатгалын хэлтсийн дарга Амарбаясгалан, мөн тус яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, тус яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтсийн дарга Саруул, тус яамны Төрийн сангийн газрын санхүүжилт бүртгэлийн хэлтсийн шинжээч Цацрал, мөн тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Сувд гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Сангийн яамнаас оролцож байгаа юм байна. ОБЕГ-аас ОБЕГ-ын дарга хошууч генерал Ариунбуян дарга хүрэлцэн ирсэн байна. Тус яамны Санхүү, ард талын газрын дарга, хурандаа Мөнхдорж тус ерөнхий газрын Санхүү хөрөнгө оруулалт хэлтсийн дарга хошууч Мөнх-Эрдэнэ, Үндэсний аудитын газрын даргаас Ерөнхий аудиторын орлогч Цэдэнжав, Санхүү-нийцлийн аудитын газрын тэргүүлэх аудитор Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Энхболд, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Чанцалдулам, мөн Нийцлийн аудитын газрын аудитын менежер Лхагвацэнд, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Эрдэнэцэцэг, Нацагдорж, Нямцэцэг, Батцэцэг, Цэгмэддорж, Ариунжаргал, Энхтуяа, Оюунхүү, Идэр, Балжинням гэсэн аудиторууд болон менежерүүд ингээд оролцож байгаа юм байна аа.

Ингээд 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх Сангийн сайдын танилцуулга болоод аудитын тайлантай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

Батсүмбэрэл гишүүнээр тасаллаа. Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Нөгөө Япон Улсад байгаа ЭСЯ-ны барилга нэг хуучирч муудсан. Монгол Улсаас бас мэргэжлийн байгууллагууд очоод дүгнэлтээ гаргачихсан шаардлага хангахгүй гээд ийм дүгнэлт гарчихсан байшин байдаг юм байна л лээ. Тэгээд энэ дээр ер нь өвөл бас асууж байсан. Энэ жилдээ нэг шийд гаргаад арга хэмжээ авна гэсэн. Энэ дээр арга хэмжээ авсан уу? Ер нь ямаршуу байдал юу гэж төлөвлөж байгаа вэ? Гадаад харилцааны сайдаас асууж байгаа юм.

Хоёрдугаарт нь Батлан хамгаалахын сайд Батлут сайдаас асуух гээд байна. Энэ БХЯ-ан дээр нэг батлан хамгаалах салбарыг дэмжих сан билүү нэг сан байгаа. Энэ сангаас бас бүтээн байгуулалт хөрөнгө оруулалт хийнэ гээд. Одоо жишээ тэгвэл Өвөрхангай аймагт байдаг 256 дугаар цэргийн анги байгаа. Энэ анги дээр нэг байшин барина хөрөнгө оруулалт хийнэ гэсэн юм яриад бас нэлээн удаж байгаа. Тэгээд энэ ер нь яг ямар шатдаа явна аа? Удаж байгаа шалтгаан нь юу байдаг юм бол? Ер нь энэ нэг Төрийн худалдан авах ажиллагааны хуультай холбоотой юм байна уу? Энэ талаар нэг тайлбар хэлээч.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Хосбаяр гишүүний асуултад хариулъя аа.

Энэ асуудлыг хөндөж тавьж байгаад 1 дүгээрт талархлаа илэрхийлье.

Хоёрдугаарт манай Япон дахь ЭСЯ-ны байр маш их хуучирсан, газар хөдлөлтийн 6 баллыг тэсвэрлэхгүй ээ. Буулгаж шинээр байр барих, эсвэл солих өөрчлөх гэсэн ийм шалгуур шаардлагыг Японы талаас нь байнга тавьсаар ирсэн. Мэдээж энэ байшинг буулгаад дахиад барихад маш өндөр төсөв гарч байгаа юм байна лээ. Тэгэхээр бараг 30-аас доошгүй тэрбум төгрөгийн зардал гарахаар байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ мэдээж бид нар төсөвт ойрын жилүүдэд чадахгүй өнгөрсөн арваад жил бас энэ асуудлыг ярьсан. Тэгээд өнөөдрийн байдлаар бол ямар ч арга хэмжээ авч чадаагүй. Ойр зуурын засварууд хийгээд ингээд торгоогоод байгаад байгаа юм. Энэ жилийн хувьд яасан гэхээр бид нар энэ ЭСЯ маань бас Монголоос мэргэж мэргэжлийн байгууллагуудыг аваачиж үнэлгээ дүгнэлт хийсэн, барилга байшингаа үзүүлсэн.

Японы мэргэжлийн байгууллагуудаар бас үнэлгээ гаргуулаад 2 янзын хувилбараар энэ асуудлыг шийдье.

Нэгдүгээрт нь энэ нэг энэ ЭСЯ-ны байр уг нь орон сууцын зориулалттай байшин. Энийг зарж борлуулах, өөр газар шинээр байр худалдаж авах, нэг бол өөр газар бид нар байшин түрээслэх гээд энэ 2, 3 хувилбараар тооцож судалгаануудаа

хийгээд бид хэд энийг бас ГХЯ-ан дээр сайдын зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлээд 2 вариант дээр бид нар тооцоогоо гаргасан.

Энийг удахгүй Сангийн яамтай бас зөвшилцөөд цаашдынхаа шийдлийг олох талаар ярилцаж байгаа. Энийг ирэх жилийн төсөв дээр бас бид нар тодорхой хэмжээнд хөрөнгө мөнгө суулгуулж чадвал засна.

Үгүй бол одоо байрлаж байгаа байрлал нь өөрөө бас нэлээн ийм үнэд орж байгаа газар. Хэдийгээр байшин нь муу ч гэсэн тэгэхдээ бид нар бас ЭСЯ байрлаж болохоор газарт өөр байр худалдаж авахад төсвөөс мөнгө гаргахгүйгээр тэр байршлаа байгаа байшингаа зараад өөр газар худалдаж авах нэг хувилбарыг бас илүү зүгээр юм болов уу гэдэг ийм байдлаар ажиллаж байгаа гэдгийг хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн нэмж тодруулах уу, зүгээр үү?

Батлут сайд хариулт нэмж өгье. Батлут сайдын микрофоныг өгье.

Д.Батлут: Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Өвөрхангай аймгийн 256 дугаар ангийн барилга байшин барихтай холбоотой асуудал улсын төсөв дээр суучихсан. 2024-өөс 2025 оны хугацаанд хэрэгжихээр 2520 онд 2 тэрбум гаран төгрөгийн хөрөнгө оруулалттай хийгдэхээр батлагдаад явагдаад явж байна. 2026 онд он дэмжиж дуусахаар явж байгаа гэдгийг хэлье ээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Батлут сайдаас. Тэр сан ер нь яг ямар ажил хийдэг юунд зарцуулагдах ёстой сан байдаг юм бэ гэдэг.

Г.Тэмүүлэн: Батлут сайд Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Д.Батлут: Хөгжлийн сантай холбоотой асуудал энхийг дэмжих үйл ажиллагаанд явж байгаа цэрэг дайчдын сургалт мөн зэвсэглэл, хувцас хэрэглэл, хоол хүнстэй холбоотой бүх асуудлуудыг эндээс гаргаж шийддэг. Түүнээс гадна одоо бас энэ салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн асуудал, зарим нэг тулгамдсан хөрөнгө оруулалтын шинж чанартай асуудлууд дээр бид бүхэн бас сайдын зөвлөл дээр ярилцаж шийдэл гаргаж ажилладаг байгаа гэдгээ хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Энэ онцгой байдлаас асууя. Энэ 2024 оны гүйцэтгэл яах вэ тоогоор байж байдаг. Бодитоор онцгой байдлын алба хаагчдын тоног төхөөрөмжийн хангамж ажиллах нөхцөл боломж хэр сайжирсан бэ? Онцгой байдлын байгууллагуудын энэ хүртээмж хэр дээшилж байгаа вэ энэ нь 2024 онд хэр хийгдсэн бэ? Нэг бодит дүн байдлаар нэг хэлж өгөөч гэсэн нэг ийм асуудал байна.

Гадаад хэргийн сайд, Гадаад харилцааны сайдаас энэ гадаадад байгаа нөгөө албан хаагчдын асуудал хэрхэн бид нар чинь өмнөх төсвүүд дээр яригдаад л байгаа. Хэрхэн шийдэгдэж байгаа. Энийг 2025 оны төсвийн тодотгол дээр ер нь яаж оруулж байгаа вэ? Энэ 2 асуултыг аваадахъя.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Ариунбуян дарга. 5 номер дээр очоод суучих уу? 5 номерын микрофоныг өгье.

Г.Ариунбуян: Баярлалаа. Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн чадавхыг сайжруулах тал дээр Улсын Их Хурал Засгийн газраас бас онцгойлж анхаарч байгаа. Сүүлийн 4 жилийн хугацаанд үндсэндээ 20-оос 30 хувиар нэмэгдсэн. Ялангуяа гал унтраах тусгай зориулалтын аврах ажиллагааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг бас гадаад улс орнуудын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэх замаар мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтад нэмэгдүүлж тусгах замаар ингээд шийдвэрлээд ажиллаж байна аа.

Одоогийн байдлаар бол 40-өөс 60 хувьтай. Цаашдаа бол энэ уур амьсгалын өөрчлөлт, гамшиг ослын тоо давтамжтай холбоотойгоор өнөөдөр цаашид ч бий болох энэ нөхцөл байдалтай холбогдуулж зайлшгүй дахиж нэмэгдүүлэх ийм хэрэгцээ шаардлага бидэнд бий.

Хоёрдугаар нь анги, салбаруудын хувьд сүүлийн 2 жилийн хугацаанд Засгийн газрын тогтоолоор 30 гаруй анги, салбар шинээр байгуулагдсан. Энэ жил бол Засгийн газрын тогтоолоор 12 анги шинээр байгуулагдахаар бид нар бэлтгэл ажлаа хангаад алба хаагчдаа сургах холбогдох бэлтгэлийг хангаад ажиллаж байна аа.

Цаашид мөн стандартад нийцүүлж алба хаагчдын тоо, анги салбарын тоог нэмэгдүүлэх замаар гамшгаас болох үйлчилгээг шуурхай үр дүнтэй зохион байгуулах бас хэрэгцээ шаардлага бий. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батцэцэг сайд асуултад хариулъя.

Б.Батцэцэг: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ жил тодотголоор бид нар орон тоогоо хасуулахгүй гэж нэлээн ярьсан. Яагаад гэхээр манай дипломат төлөөлөгчийн газруудын орон тоо бол яг хасах ямар ч боломжгүй байгаа.

Хоёрдугаарт зардлын хувьд ч гэсэн ер нь урсгал зардлын 80 хувь нь дипломат төлөөлөгчийн газруудад оногддог. Төвд бол 20 хувь нь оногддог. Хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөр эд нар байхгүй учраас манай зардлаас хасах ямар ч ийм аргагүй байгаад байгаа. Харин ч бид нар жилийн жилд ханшийн зөрөөнөөс болж нэлээн алдагдалд ордог. Тэгээд одоо хүлээгдэж байгаа зүйл гэвэл Бразилд бид нар ЭСЯ-аа сэргээж байгуулах ёстой. Тэр бүс нутагт ерөөсөө ЭСЯ Кубээс өөр газар байхгүй.

Тийм учраас энэ бас манай харилцаанд их чухал учраас энийгээ нээе гэж байгаа. Испани улсад бас ЭСЯ байгуулахаар бэлтгэл ажлаа хангаад айлын талтай тохироод дипломат шугамаар тохироод байгуулахаар болсон байгаа. Энэ зардлуудыг бид нар бас хасуулахгүй гэдэг ийм саналтай байгаа. Манай дипломат төлөөлөгчийн газруудад нэг ийм нөгөө иргэдэд туслах сан гэж байдаг. Энэ зардал бас хасагдахаар болж байгаа. Энэ зардал дандаа голдуу хилийн чанадад хүнд өвчин зовлон туссан, голдуу амь нас үрэгдсэн нас барсан иргэдийн шарилыг зөөх болон бас хилийн чанадад хэрэг төвөгт холбогдож бас хоригдож байгаа иргэдээ

эргэх гэх мэт ийм зардалд зарцуулагддаг. Энэ төсвийг бас хэвээр нь хадгалахыг хүсэж байгаа.

2025 онд бол бид нар болж өгвөл бас жоохон тэлэх ийм саналтай байгаа. Саналаа Сангийн яаманд бас хүргүүлээд ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Магнайсүрэн даргаас асуугаадахъя. Энэ та бүхэн энэ гадаадад байгаа байгууллагуудынхаа шалгалтыг ер нь яаж шийдэж байна? Тийм хүндрэл чирэгдэл их хэрэг гаргадаг. Ер нь сураг сонсоход бол бараг л жилийнх нь өртөг шиг л хүмүүс очоод л шалгаад байдаг сураг дуулддаг. Энэ гадаадад байгаа байгууллагуудын шалгалтыг яаж үр дүнтэй хийх аргачлал байдаг юм, энийг яаж хийж байгаа юм. Хөөш дарга нь хариулахгүй юм. Даргаас нь асуусан шүү дээ. Юун орлогч нь байгаа юм бол боль л доо та нар. Тэгвэл тэгээд дарга нь яах гэж байгаа юм?

С.Магнайсүрэн: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Ер нь ерөнхий зарчмын хувьд 2 жилд нэг удаа энэ дипломат байгууллагуудыг шалгаж байгаа. ГХЯ-тай Сангийн яамтай хамтраад ийм шалгалтууд явдаг. Тэгээд яг таны хэлж байгаа тэр процессын хувьд би сайн мэдэхгүй байгаа учраас манай санхүүгийн туршлагатай санхүүгийн даргаараа хариулчихвал болохгүй юу гишүүн ээ?

Г.Тэмүүлэн: 4 номер нэмж хариулъя.

Ц.Наранчимэг: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Гадаад харилцааны сайдын нийт төсвийн 75.9 хувийг гадаад оронд суугаа дипломат төлөөлөгчийн газруудын төсөв эдэлж байгаа. Төсвийн тухай хуулиар бол эдгээр газрууд маань төсвийн шууд захирагчийн үүрэг гүйцэтгэж байгаа. Уг нь төсвийн тухай хуулиар жил болгон төрийн аудитын байгууллага дүгнэлт гаргах үүрэгтэй. Гэхдээ бид төсөв мөн тухайн дипломат төлөөлөгчийн газруудад байгаа эрсдэл хаана очиж аудит хийх ёстой вэ гэсэн энэ асуудлаа судлаад 2 жилд нэг удаа очиж санхүүгийн тайлангийн аудит хийж дүгнэлт өгч байгаа.

Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Одоо чинь гүйцэтгэл байгаа тийм ээ? Ариунбуян генералаас асуулт асууя. Бид нар ингээд төсөв хэлэлцээд яваад ингээд гүйцэтгэл ярьж байна аа. Сая манай Сэлэнгэ аймагт ой хээрийн асар том түймэр гарлаа. Ер нь том зургаараа энэ чинь гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдал зарлах хэмжээнд хүрлээ гээд иргэд бас маш их санал гаргаж байсан. Манай Жавхлан сайд бас тус тойргоос сонгогдсон гишүүн бид нарт бас хандсан удаа дараа хандсан. Тэгээд яг ингээд 4 сард түймэр гарч эхлэхэд буюу 2 сарын өмнө эхний түймрүүд гарсан. Тэгээд газар дээр нь очоод ажиллахад манай онцгой байдлын алба хаагчдын техник тоног төхөөрөмж хангамж муу байна аа. Хувцаснууд ямар ч байсан солигдсон.

Тэгээд гал унтраах нөгөө үлээгч нь болох юм бол хүчин чадал багатай хямд. Нөгөө 400 гаран мянган төгрөгийн хамгийн үнэтэй нь 1 сая төгрөг байлаа гэхэд 3 зэрэглэлийн үнэтэй байлаа гэхэд хамгийн хямдхан нь хуучирсан амархан мотор нь шатдаг. Тэгээд үндсэндээ энэ мэдээж энэ иргэний хариуцлага байгаль орчиндоо ээлтэй аюулгүй зорчих, аялах, зугаалах гээд олон төрлийн шалтгаан бий л дээ. Гэхдээ яг гал түймэр гарчхангуут түүнийг хүний хүчин зүйлээс илүүтэйгээр техник тоног төхөөрөмжийн боломж муу байгаа нь харагдсан.

Сэлэнгэ аймаг дээр жишээлбэл тэр явуулын хөдөлгөөнт удирдлагын газар нь тоноглол байхгүй байх жишээний. Дархан-Уул аймаг дээр бүхэл бүтэн аймаг гол устай газар усанд шумбаад хүний амь авардаг хувцас ганцхан ширхэг байгаа байхгүй юу. Тэр чинь зэрэг зэрэг аюул гарвал яах вэ гээд. Тэгэхээр үндсэндээ ингээд харж байхад бол энэ тоног төхөөрөмж хангалтын асуудал учир дутагдалтай байна аа. Он гараад л энэ чинь усанд живээд нас барчихсан тохиолдол хэд хэд гарчихлаа шүү дээ.

Тэгэхээр ингээд яг энэ гүйцэтгэл чинь энэнтэйгээ хэр уялдаж байгаа юм бол. Өөрөөр хэлбэл энэ чинь бид нар ингээд л төсөв батлаад байдаг тодорхой орон тоо наана цаана гээд байдаг. Яг бодит амьдрал дээр энэ онцгой байдлын үйл ажиллагааг түргэн шуурхай явуулахад л энэ чинь хэрэгтэй шүү дээ. Тэгээд яг шулуухан хэлэхэд тэр гал түймрийн асуудал гарсан угаартагч хүний амь нас жил гарны өмнө 2024 оны 1 сарын 21-ний шөнийн 0:00 цагт нөгөө Дүнжингаравын дэлбэрэлт гээд л ярьдаг. Стандартын ажил байна. Зарим хүмүүс нь нөгөө нэг юмаа хэмнээд маскгүй орчихлоо эд нар гэсэн ярианууд гараад байдаг. Яг сая Сэлэнгэ дээр бол Дархан Сэлэнгийн бүс дээр бусад аймгуудаас татагдаж очсон.

Жишээлбэл Улсын Их Хурлын зарим гишүүд бид нар гал унтраагч урдаас захиалж авчраад 30 ширхгийг өгч байгаа байхгүй юу. Тэр нь зүгээр л тэр чинь гишүүн хувийн санаачилгаар явж байна шүү дээ. Уг нь улс юм чинь энэ дээр онцгой байдал энэ дээр маш сайн хандах ёстой байхгүй юу.

Тэгэхээр та асуух асуулт нь наймхан секунд үлдчихээд байна. Яг энэ гүйцэтгэл чинь энэ нөхцөл байдлыг бүрэн хангахтайгаа яаж уялдаж байгаа талаар нэг та тайлбар өгөөч? Маш тодорхой.

Г.Тэмүүлэн: 5 номер. Ариунбуян дарга Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Г.Ариунбуян: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя аа. Нөхцөл байдал бас хүнд байгаа. Үнэхээр ингээд онцгой байдлын байгууллагын техник тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулж 100 хувь хүргэхэд ойролцоогоор дунджаар 800-аас 900 тэрбум төгрөгийн хэрэгцээ шаардлага байгаа. Бид нар жилд дунджаар 20-оос 25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж байна. Мэдээж ашиглагдах явцад эвдэрч гэмтэх засвар үйлчилгээ хийх гээд л байнгын л ашиглалтад байдаг ийм асуудал байгаа. Ийм хүндрэл бэрхшээл байна. Дээр нь бид бүхэн юу гэдэг юм энэ гал унтраах ажиллагаанд ашиглаж байгаа үлээгч аппарат бусад төрлүүдийн багаж хэрэгслийг авбал байгаа төсөвтөө тааруулаад л аль болохоор их хэмжээтэй тэгэхдээ үнэ өртгийн хувьд бас хамаагүй бага биш нэг дундаас доош түвшинд ингэж л авч хэрэглэж байгаа юм. Үнэтэй юм авахаар тоо нь багасаад байдаг ийм зовлон бас байна аа.

Дээр нь алба хаагчдын орон тооны хувьд бол ойролцоогоор гал унтраах эрэн хайх салбар нэгжид нийлээд улсын хэмжээнд 8 мянга байх ёстой стандартын дагуу. Өнөөдөр бид нар дөнгөж 40 гаруй хувийн хангалттай байгаа.

Тийм учраас бүх анги салбаруудаа энэ Сэлэнгэ аймаг руу татсан. Цаана нь үлдэж байгаа бүрэлдэхүүн ямар ч ээлж солих боломжгүй. 24 цагаар бүтэн сарын хугацаанд 3 сарын хугацаанд ангийн байрлал дээрээ ажиллаж байгаа. Ийм л нөхцөл байдалтай байна. Тэгээд цаашдаа бол энэ стандартад нийцүүлж орон тоог нэмэгдүүлэх техник тоног төхөөрөмжийн чадавхыг бэхжүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар энэ чадавхыг сайжруулах асуудал их чухал байгаа юм гэдгийг хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Тэгэхээр Сангийн сайдад бас хандаж хэлэхэд бас мэдээж зовлон их байгаа. Бид нар яг энэ Монгол хүний амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөөг хамгаалах, шууд болон шууд бус утгаараа үндэсний аюулгүй байдалд заналхийлэл учруулах ингэхэд нь нөхцөлдүүлэх ч хүчин хүчин зүйл болж байгаа энэ төсөвтэй холбоотой асуудал дээр арай өөрөөр хандах ёстой болчихоод байгаа юм аа. Нөгөө дахин дахин Магнайсүрэн даргад өчигдөр ч гэсэн бас хэлсэн шүү дээ. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд төсөв нийцэж байгааг детальчилж шалгах шалгуур нь байхгүй гээд байгаа шүү дээ. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын аюулгүйн зөвлөл энийг гаргах ёстой юм байна лээ. Тэгээд та нар энэ саналаа гялс өгөөд явмаар байгаа юм. Бод л доо 800, 900 тэрбум төгрөг гэж байгаа.

Тэгээд 1 хөнжлийнхөө хэмжээгээр хөлөө жийнэ гээд л төсөв тавьдаг. Тэр нь юманд нь хүрдэггүй. Эргээд юу болж байна гэхээр энэ чинь хүний амь нас байгаль орчны асуудал гээд том юм болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр арай жоохон цогц бодлого Амарсайхан Шадар тэр шадар сайд энийг чинь хариуцаж байгаа шүү дээ.

Энийгээ сайн ингэж ойлгуулж орж ирмээр байна.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн нэмж асууя.

С.Эрдэнэболд: Батлан хамгаалахын Батлут сайдаас асуухад нөгөө 7 сарын 1-ээс 12 сарын 30 нэгнийг дуустал хагас жилийн нөгөө цалин пүнлүү байхгүй болчихоод байх шиг байна тийм үү? 7 тэрбум төгрөг хасагдсан гээд байгаа. Тэгээд энэ чинь бид нар нөгөө Монгол Улсын төлөө зүтгэ гээд тангараг өргүүлээд явж байгаа нөхдүүдийгээ мөнгө төгрөггүй болгоод ингээд хаячихдаг бас ингээд энэ чинь логик нь алдагдаад байгаа байхгүй юу. Мэдээж нөгөө ойлгож байгаа бүсээ чангал л гээд байдаг тэ? Бүсээ чангал гээд байдаг. Гэхдээ яг юун дээр бүсээ чангалах вэ гээд илүү дарга анги дээр л бүсээ чангалах ёстой гээд байгаа болохоос биш яг энэ тангараг өргөсөн алба хаагчдын асуудал дээр бид нар бас бүсийг яаж чангалах вэ гэдгээ бас арай илүү уялдаатай бодож баймаар байгаа юм. Энэ дээр Батлут сайд та нэг мэдээлэл өгөөд Сангийн сайд энэ тал дээр бас нэг тайлбар өгөөч гэж хүсмээр байна.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний асуултад Батлут сайд.

Д.Батлут: Өнөөдөр энэ цаг хугацаанд дэлхий даяар геополитикийн хурцадмал байдалд нэлээн газар авчихсан улс орнууд батлан хамгаалах салбараа өөд татах, тэнд салбарын зардал мөнгийг нэмэгдүүлэх ДНБ-ий бүр 5 хувь руу тэмүүлэх ийм шийдлүүдийг зарим улс орнууд ч гэсэн гаргаж байгаа. Энэ цаг хугацаа байна л даа. Тэгэхдээ энэ жил энэ удаад манай Монгол Улсын төсөв санхүү үнэхээр хүнд байгаа цаг хугацаа. Бид бүхэн хэмнэлт дээр тодорхой өөрсдийнхөө байр суурийг Засгийн Засгийн газар, Сангийн яаманд илэрхийлж байгаа.

Тэгэхдээ 1 асуудал бол энэ жил гадаад, дотоодын академид өгч байгаа офицер, ахлах ахлагч нарын 7 дугаар сарын 1-ээс 12 дугаар сарын 31-ийг хүртэл хагас жилийн цалин хөлс ер нь байхгүй байгаа. Бид нар тайван цагийн орон зай тооныхоо хязгаараар батлагдчихсан төсөвтэй явж байгаа учраас энэ төсөв байхгүй байгаа. Бид нар тэр хүмүүсийг цалинжуулах асуудал дутмаг болж 7 тэрбум гаран төгрөгийн.

Г.Тэмүүлэн: Батлут сайд нэмж гүйцээж хариулъя.

Д.Батлут: Тэгээд энэ төгсөгчдийн хагас жилийн цалингийн сан болох 7 тэрбум гаран төгрөгийн асуудал нэлээн хурц тавигдчихаад байгаа юм аа. Тэгээд энэ мэдээж ажлын байр нь бэлэн байгаа шууд ажилдаа орох тусдаа хүмүүс байдаг. Тэгээд цалингийн сан нь байхгүй байгаа учраас энэ асуудалд бас анхаарах шаардлага гарчхаад байгаа гэдгийг хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд нэмж хариулах уу? Эрдэнэболд гишүүний асуултад.

Б.Жавхлан: Эрдэнэболд гишүүн хэдүүлээ салбар салбараа хамгаалах юм бол бүх салбарыг хамгаалмаар байна. Хүчний байгууллагуудыг ингээд БХЯ, Хилийн цэрэг манай онцгойг бүгдийг нь л хамгаалаад хүн болгон л яриад унана. Тэгээд энд яриад хэрэггүй гэж би зөвлөө. Бид хэчнээн хүсээд хүсээд бид төсвийнхөө хязгаар дотор л баригдана. Харин ч манай онцгойгийнхонтой бид их маш сайн ойлголцоод ингээд ажиллаж явж байгаа. Ер нь бол одоо энэ Засгийн газрын нөөц санг бид нар 50 тэрбумаар нэмж байгаа. Энэ нь үндсэндээ бараг л онцгой руу явна даа. Энэ намар.

Тийм учраас цаашдаа бид онцгойгийн яг өнөө маргаашдаа шийдэх зардлууд дунд урт хугацаанд шинэчлэх асуудлууд гээд хөтөлбөрийн хэмжээнд яригдаад ингээд судлаад эхэлсэн байгаа. Ер нь 2026 оны төсөв.

Г.Тэмүүлэн: Гүйцээж хариулъя Жавхлан сайд.

Б.Жавхлан: 2026 оны төсөв дээр бид бас ярилцаж байгаа зүйлүүд байгаа. Тэр үед харин гадаад зээл тусламжаар бас эдний салбар дээр хэрэгжих төслүүд орж ирнэ. Тэрийг харин дэмжиж өгөөрэй.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 2024 онд төсвийн гүйцэтгэлтэй холбоотой нэг асуултыг бас нэг нэмж тодруулж асууя.

Аудит Гадаад харилцааны яам бас энэ дээр нэмж тодруулга тайлбар өгөөрэй. Төсвийн гүйцэтгэлийг аваад үзэхээр үндсэндээ ГХЯ-ны зарлагатай холбоотой зарлагын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэг анхаарал татаж байгаа нэг асуудал

байгаа. Нөгөө төлөвлөгөө нь зарлагынх нь төлөвлөгөө нь 207 тэрбум гэж байсан. Үүнээс гүйцэтгэл нь 152.4 тэрбум буюу 73.6 хувийн гүйцэтгэлтэй гарч ирж байгаа.

Тэгэхээр энэ дээр үндсэндээ гүйцэтгэл дээрээсээ аваад үзэх юм бол зарлагын төлөвлөгөө бол 54.5 тэрбум төгрөгийн зөрүүтэй гарч ирж байна гэж харагдаад байгаа юм. Тэгээд би энэн дээр ер нь яагаад ГХЯ-ан дээр ийм бараг 27 хувийн гүйцэтгэл дээрээ зарлага дээрээ ийм зөрөө гарч ирэв ээ? Их том дүнтэй зөрөө гарч ирэх юм.

Доош нь гүйлгээд аваад үзэхээр үндсэндээ дипломат төлөөлөгчийн газар дээр 157.2 тэрбум төгрөг гарах байсан бол 113 тэрбум төгрөг гээд 71.9 хувийн гүйцэтгэлтэй 44.2 тэрбум төгрөгийн зарлагын зөрөө энэ дээр ингээд үүсэж байна гэж харагдаж байгаа юм.

Тэгэхээр энд ямар том өөрчлөлт гараад ийм зөрүү ингээд үүссэн юм бол. Гадаад харилцааныхаа яаман дээрээ 8.9 тэрбум төгрөгийн бас зөрөө үүссэн байна. Яаман дээрээ 73.4 хувийн гүйцэтгэлтэй байна гэж гарч ирж байгаа юм. Тэгээд энэ дээр нэг ГХЯ-аас нэг тайлбар мэдээлэл өгөөч ээ. Аудитын хийсэн товч мэдээлэл болоод тайлан дүгнэлт дээр та бүхэн маань орлогын төлөвлөгөөг үндсэндээ төлөвлөж сайжруулаач гэсэн ийм зүйлийг хэлсэн байгаад байгаа. Гүйцэтгэлтэй холбоотойгоор зарлагын төлөвлөлттэй холбоотойгоор бас ямар нэг дүгнэлт хийсэн үү? Би яг ирүүлсэн товч мэдээлэл дээр яг ерөнхий зүйл байхгүй байгаа. Аудит бас нэмээд хариулах зүйл нь ГХЯ-ан дээр аудитаар нийт 5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 3.1 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зохих албан шаардлага хүргүүлсэн гэсэн энэ зүйлийг хэлсэн байгаа.

Ер нь бол энэ ГХЯ-ан дээр 5, БХЯ-ан дээр 6.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн гэж байгаа. Эдгээрийг та хэд маань бас яам яамаар нь багцлаад яг ямар байгууллага дээр ямар хэмжээний зөрчлүүд илэрсэн юм бол? Алдаа зөрчил дутагдлуудыг бас хэрхэн залруулж байгаа юм бол гэдэг мэдээлэл бас нэмж өгөөч гэх гэсэн юм. Батцэцэг сайд асуултад хариулах уу? Дараа нь аудит.

Б.Батцэцэг: Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

Энэ төрийн хэмнэлтийн хуулийг бид нар хэрэгжүүлж байсан. Энэ 2022-оос 2024 онд маш олон хурал онлайн онлайн хэлбэрт шилжсэн. Бодитоор ирэх явах зардлууд хэмнэгдсэн байгаа. Шуудан холбоо, шатахуун, сургалт сурталчилгаа, ном товхимол хэвлэх зардал энэ зардлуудыг хэмнэсэн байгаа. Мөн ОУБ гэрээ конвенцын татварууд байдаг. Энэ ковидын үеэр бас нэхэмжлэлүүд нь ирээгүй 2 жил хойшилсон. Тэрнээс болоод энэ 8 тэрбум төгрөг хэмнэгдсэн гэсэн үг. Зарим нь шилжсэн. Дипломат төлөөлөгчийн газрууд дээр урсгал зардлын хувьд 44 тэрбум төгрөг бас тухайн жилдээ ашиглагдаагүй. Энэ нь бид нар Ташкентад буюу Узбекистанд, Индонез буюу Жакартад Испанийн Мадридад ЭСЯ нээх, Бангкок ЭСЯ-ны дэргэд Консулын хэлтэс бусад дипломат төлөөлөгчийн газруудад орон тоо нэмэхээр төсөвлөгдсөн байсан. Энэ нь яг тайлант жилдээ бас амжаагүй. Дараа жил рүү нь зарим айлын талын чөлөө зөвшөөрөл тохиролцооноос болоод хойшлогдсон энэ асуудлаас болоод энэ 44 тэрбум төгрөг хэмнэгдсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Аудит нэмж өгөх тайлбар байна уу? Хэн хариулах вэ? 4 номер Наранчимэг дарга.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын тайлангийн нийт зөрчлийнх нь дипломат төлөөлөгчийн газрууд буюу төсвийн шууд захирагч нар энэ дээр ГХЯ-аас хамаарахгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын ЗГХЭГ-аас Дипломат төлөөлөгчийн газрын арилжааны банкны дансанд дипломат төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны санхүүжилттэй холбоогүй тайлан тоонд хамаарахгүй зардлыг оны эцсээр 2.5 тэрбум төгрөгийг шилжүүлж шилжүүлсэн учраас үүнийг нь ГХЯ өглөгөөр бүртгэсэн байгаа.

Тэгэхээр Төсвийн тухай хуульд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүрэгт өглөг авлагыг үүсгэхгүй байх гэсэн энэ асуудал байгаа. Тэгэхээр энийг бүртгэл тайлагналтай холбогдуулаад энийг өмнө нь төрийн аудитын байгууллагаас зөвлөмж өгсөн. Энэ удаагийн тайлангаар албан шаардлагыг өгсөн байгаа.

Мөн энэ тайлан дотор одоо өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өглөгийн бүртгэлтэй холбоотой бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудлууд байгаа. Төрийн аудитын байгууллага аудит хийгээд явж байхад дандаа алдаа зөрчлийг илрүүлээд байдаггүй.

Гадаад харилцааны сайд бол манай тайланг хүлээж аваад бүх төсөв захирагч нартаа төлөвлөгөөгөө албан даалгаврыг гаргаж өгдөг ганц яам бол ГХЯ байгаа. Төрийн аудитын байгууллагаас өгч байгаа энэ алдаа зөрчлийг засан сайжруулах талаар бүгдээрэнд нь албан шаардлага аргачлалыг хүргэж ингэж хэвшсэн яам бол Гадаад харилцааны яам байгаа.

БХЯ-ны тухайд бол санхүүгийн тайлангийн аудитаар нийт төсвийн шууд захирагчдын хүрээнд мөн төсвийг үр ашигтай зарцуулаагүй хөрөнгө оруулалттай холбоотой, Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой ийм зөрчлүүд бол илэрсэн. Энэ зөрчлүүд дээр нь бид албан шаардлагуудыг өгсөн байгаа. Мөн анги салбартай холбоотой орон тооны албан тушаалын орон сууцыг бүртгэлжүүлээгүй гэсэн ийм бас албан шаардлага өгсөн.

Төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт албан шаардлагыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчлүүд илэрсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Аудитаас саяын тэр Гадаад яамны зарлагын зөрөөтэй холбоотойгоор тайлбар мэдээлэл өгөх зүйл байгаа юу? 27 хувийн зөрөө үүссэн. Тэрэн дээр та хэд маань бас яг ямар дүгнэлт бодит анализ хийсэн. Гол асуудал нь зүгээр бид нар энэ зардлын эх үүсвэрийнхээ боломжит түвшиндээ уг нь төлөвлөдөг байх эргээд илүү төлөвлөлтийг бас зөв хийдэг байх, үр ашгийг хангах, төсвийн сахилга баттай байх гэдэг энэ асуудал талаасаа л хандаж үүсээд байгаа юм. Тэгэхээр 27 хувь гэдэг бол өөрөө бас том дүнтэй зөрөөгөөр үүсэж байгаа учраас 4 номер, Наранчимэг дарга.

Ц.Наранчимэг: Гадаад харилцааны сайдын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд бид төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой саяын илэрсэн асуудлуудыг гаргаад нийт энэ дээр төсвийн төлөвлөгөөг төсвийн

ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, жилийн төсвийн хязгаартай уялдуулж үндэслэлээ боловсруулж байх ёстой юм байна аа.

Ялангуяа 50 дипломат төлөөлөгчийн газруудаас 38 дипломат төлөөлөгчийн газар нь туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй туслах үйл ажиллагаанаас 2.8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна аа.

Тэгэхээр орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй бодитой төлөвлөж байх шаардлага байна гэсэн ийм дүгнэлтийг өгсөн. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Өдрийн мэнд. Энэ Үндэсний Аудитаас асууя. Энэ танай тайлан дээр татварын байгууллагаас татварын бүрдүүлэлттэй холбогдолтой 7.4 их наядын гэмт хэргийн шинж чанартай зөрчил нийт татварын авлагын 26.7 хувьтай тэнцэж байна гэж байгаа байхгүй юу. Тэгээд үүнтэй яг адилхан асуудал болохоороо НДШ-ийн сан дээр байдаг. Нөгөө банкнуудад тавиад алдчихсан. Тэгэхээр аудит энэ асуудлуудынхаа хойноос яаж үр дүн хариуцлага тооцох асуудлуудыг шийддэг вэ? Энэ олон жил болж байна шүү дээ. Сангийн сайдаас асууя. Цомхотголд хийж байна. Төсвийн цомхотгол хийж байна. Орлого буурсан. Гадаад нөхцөл байдал хүнд бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгээд үүнийхээ энэ 7.4 их наядын зөрчил.

Нийгмийн даатгалын сангийн 270 орчим тэрбум төгрөгийн асуудал. Үүнийхээ зөрөө алдагдал нөхцлийг та нар хаанаас нөхөөд байна вэ гэхээрээ шударгаар татвараа төлж байгаа иргэд ААН-ээс данс хаадаг, торгууль тавьдаг, акт үйлддэг. Тэр хүмүүс дээрээ торгууль тавьж энэ төсвийн алдагдлыг нөхөх оролдлого хийж байна. Одоо орж ирж байгаа 9 хувь буюу төрийн албан хаагчдын цомхотгол хийж байгаа. Түүн дээр нь тусгай мэргэжлийн мэргэшсэн цол зэргийн мэргэшсэн хүмүүсийнхээ нэмэгдлийг бас танаж орж ирж байгаа. Энэ улсад чинь онцгой байдлын албан хаагч, төрийн тусгай албаны өндөр мэргэшсэн хүмүүсийг маш бага цалингаар тэр нэмэгдлээр л барьж байгаа шүү дээ. Тэгээд тэр нэмэгдлийг нь байхгүй болчих юм бол энэ төрийн албан хаагчид яаж ажиллах юм. Тэгээд энэ ийм олон мөнгө алга болж байгаа төсвийн хулгайнхаа шийтгэлийг ард иргэдээсээ, ААН-ээсээ, төрийн албан хаагчдаасаа шийтгэж энэ төсвийнхөө алдагдлыг зохицуулаад байна шүү дээ. Энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ. Энэ нийгмийн даатгалын сангийн асуудлууд өчнөөн жил яригдаж байна. Тэгээд энэ өнөөдөр ингээд бас аймаар том тоо. Энэ 2024 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын дүн дээр 7.4 их наяд нийт татварын орлогын 26.7 хувь.

Тэгээд энийг чинь зүгээр бид нар ард иргэд ААН-үүд шударга шүү. Ихэнх нь бас татвар төлөхгүй байгаа. Тэгээд төрийн албан хаагчид, төрийн албан хаагчдыгаа цомхотгоод 9 хувь механикаар цомхотгоод. Тэгсэн мөртөө хяналтын менежер, бүтээмжийн менежер гээд дарга нарыгаа нэмчихсэн. Энийг хэзээ болих юм бэ?

Г.Тэмүүлэн: Анар гишүүний асуултад хариулъя. Аудит эхлээд хариулъя. Дараа нь Сангийн яам, Жавхлан сайд, Аудитаас хэн хариулах вэ? 4 номер Наранчимэг дарга.

Ц.Наранчимэг: Анар гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Татварын байгууллагаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа яваад татвар хураалттай холбоотой ажлуудыг хийж гүйцэтгэх явцдаа гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нэмэгдсэн өртгийн албан татварын хий бичилттэй холбоотой 950 тэрбум төгрөг, бусад гэрээ, бараа ажил үйлчилгээтэй холбоотой гэмт мөнгө угаасан байж болзошгүй 6.3 тэрбум төгрөгийг Татварын алба хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байгаа юм. Тэгэхээр татварын алба татварын байцаагч нар маань ажлаа хийж байх явцдаа мэдээж шууд гэмт хэргийн шинжтэй гэж үзэхгүй, болзошгүй ийм мөнгийг шилжүүлсэн байна гэдгийг аудитын байгууллага гаргаж ирсэн. Энэ асуудалтай холбогдоод төрийн аудитын байгууллагаас ХЗДХ-ийн сайдад татварын байгууллагаас хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн мөнгө угаасан байж болзошгүй татварын бүрдүүлэлт, ногдуулалттай холбоотой гэмт хэргийн шинжтэй хэргүүдийг шийдвэрлэх ажиллагааг хууль, эрх зүйн орчныг нь сайжруулж энэ дээр тодорхой шийдлүүдийг гаргаж өгөхөөр бол зөвлөсөн байж байгаа.

Тэгэхээр төрийн аудитын байгууллага нийгмийн даатгалын мөн энэ данснуудад байгаатай холбоотой энэ асуудлуудыг санхүүгийн тайланг нь баталгаажуулахдаа энэ төлбөрүүдийг бодитой байх оршин байхгүй байна гэдэг ёстой стандартынхаа дагуу хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэлээ гаргаад явж байгаа.

Аудитын байгууллагаас өгч байгаа зөвлөмжийн дагуу жил бүр тодорхой ажлуудыг хийгээд энэ авлагуудаа барагдуулж байгаа. Мөн энэ дээр байгаа хураагдсан хөрөнгүүдийн хөрөнгийн чанар алдагдах ийм эрсдэл байна шүү гэдгийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд бас дүгнээд гаргаад өгчихсөн байгаа.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд асуултад хариулъя.

Б.Жавхлан: Анар гишүүний шүүмжлэлтэй ер нь санал нийлж байна. Тэгэхдээ бид энийг шийдэх ёстой. Төсвийн шинэчлэл гэвэл яг л таны хэлж байгаа энэ асуудал юм байгаа юм. Бид судалгаа гаргаад Улсын Их Хуралд хүргүүлсэн байгаа. 204 хуулиар мянга гаруй заалтаар бид аль хэдийн хуулиар төсвийн хуваарилалтыг шийдчихсэн байж байдаг. Төсвийн хуулиараа аль хэдийн хуваарилчихсан. Энийг харин бид төсвийн орлогодоо багтааж арайхийж төсөв боож орж ирдэг гэсэн үг. Ингээд Их Хурлаас бас бидэнд үүрэг өгсөн. Энэ эрх зүйн зохицуулалтуудаа оруулах алийг нь одоо зогсоох юм, алийг нь бүүр хүчингүй болгох юм. Алийг нь хойшлуулах юм хуулиудаараа. Энэ саналуудаа бэлдсэн байсан. Сая тодотголоор оруулах гэхээр энэ тодотголоо ч хийж амжихгүй чуулган ч хуулийнхаа хугацаанд тарахгүй ийм бас хугацаа сунгах эрсдэл байгаа учраас бид түр хойшлуулсан.

Ингээд 9 сард төсвөө өргөн барихдаа бид дор хаяж 42 хууль дээр өөрчлөлт хийхээр оруулж ирнэ. Тэр үед та яг ингээд хамгаалж өгөөрэй. Энэ дээр туслаарай, хамтарч ажиллаарай. Тэгэхгүй бол бид энэ төсвийн шинэчлэл гэдэг юмыг эд нар хийж чадахгүй. Харин санал нийлэхгүй байгаа нэг зүйл энэ татварын орлого бүрдүүлэлт, татвар хураалтыг татварын байцаагч нар татварын байгууллагад битгий бурууг тохоорой. Энэ хүмүүс чинь төрийн албан хаагч нар бас л ажлаа хийж

байгаа юм. Хуулиараа олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд үүргийнхээ хүрээнд ажлуудаа хийгээд явж байгаа.

Харин энэ төсөв дээр ачааллууд нэмж байгаа эрх зүйн зохицуулалтуудаа л бид нар маш түргэн хийхгүй бол цаашдаа энэ байдал хэзээ ч засагдахгүй улам л ороогдоод ингээд яваад байна. Тийм танд баярлалаа.

Санал хэлсэнд Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Жавхлан сайдаа энэ аудитаас дахиад тодруулъя.

Энэ Капитал банк, Чингис хаан банк та хэлж энэ хууль хүчний байгууллагад өгөөд байх асуудал шийдэгдэж байна. Өнгөрсөн хугацаанд нийт өрийн 207 тэрбумыг, өрийн 22 хувь буюу 47 тэрбумын л өр авлагыг барагдуулсан. Хөрөнгийн үнэлгээ бага гээд тэгэхдээ энэ шүүхийн шийдвэрээр л энэ чинь ямар ч зээлийн хүү, алданги тооцохоо больчихсон, зогсчихсон байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг эргээгээд энэ үр дүнг нь зөрүүг нь ерөөсөө татвараас нөхөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр нэг цаашлаад цаашдаа нэг шуурхай арга хэмжээ авч сурмаар байгаад байна. Сая Жавхлан сайд тэр би татварын албан хаагчдын талаар яриагүй.

Татварын албан хаагчид, татварын байгууллага ажлаа хийж байгаа. Үндсэндээ энэ эдийн засгийн үндсэн суурь, орлого бүрдүүлэлт орлогыг нь цоорхойгоо нөхөж байгаа энэ тогтолцоо шоблом нь өөрөө буруу байна гээд байгаа юм. Би өөрөө маш олон жил энэ олон улс болон дотоодоос хөрөнгө оруулалт татаж компанийг удирдаж явсан хүн. Үнэхээр улсын төсвийг ингэж бүрдүүлдэг ингэж асуудлаа нэг жилийн дараа 4 төсөв орж ирдэг. Би өөрөө эдийн засагч хүн биш. Гэхдээ наад захын эдийн засаг, санхүү, бүртгэлийн аргаас харахад л бүр үнэхээр үнэхээр шокт ороод байгаа байхгүй юу. Яаж ийм байж болдог юм бэ 4 жилд 4 удаа төсвөө тодотгоод. Тэгээд энэ улсын төсөв тасрах гээд байгаа нь үнэн. Тэгээд тэрийгээ нөхөхдөө шударга иргэдээ ингэж шийтгэж байгаа маркаар асуудлыг шийдэж байгаа. Маш олон төсвийн таналтын боломжууд байгаа шүү дээ. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хөлс, зарим нэгэн төсөл хөтөлбөрүүд.

Та өмнө нь 2024 оны төсвийн тодотгол дээр нүүрсний үнэ дээр асуудалгүй л гээд байсан. Үгүй энэ чинь эрсдэлтэй юм биш үү гэсэн асуудалгүй гэсэн. Одоо болохоор асуудалтай л гээд байгаа юм.

Г.Тэмүүлэн: Аудит 4 номер дараа нь Сангийн сайд.

Ц.Наранчимэг: Чингис хаан банканд байршиж байгаа Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн өмнөх үлдэгдэл 94.9 тэрбум төгрөгөөс тайлант онд 1.5 хувь буюу 1.5 тэрбум төгрөг барагдуулаад бид нарын саяын баталгаажуулсан 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар 93.4 тэрбум төгрөгийн авлага эрсдэлтэй байна гэж дүгнэсэн. Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 68.2 тэрбум төгрөг өмнөх оны авлагаас 3.7 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг барагдуулаад 65.7 тэрбум төгрөгийн ажил удаашралтай байна гэж ингэж дүгнэсэн байгаа.

Тэгэхээр төрийн аудитын байгууллагын хуульд заагдсан бидний эрх хэмжээ бол өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжихгүй бол албан шаардлага өгнө. Албан

шаардлага хэрэгжихгүй бол хариуцлага тооцох. Албан шаардлагыг томилдог эрх бүхий албан тушаалтнуудад нь өгдөг ийм хуулийн зохицуулалттай. Төлбөрийн акт тогтооно. Тэгэхээр энэ дээр манай байгууллага.

Г.Тэмүүлэн: Гүйцээж хариулах уу? Наранчимэг дарга 4 номер.

Ц.Наранчимэг: Барагдуулалт удаашралтай байгаа учраас бид хариуцлага тооцох албан шаардлагыг өгөхөөр яг энэ банкнуудтай холбоотой асуудлыг хариуцдаг хүмүүс маань бас жил болгон ерөнхийдөө солигдоод явж байгаа.

Тийм учраас бид нар авлагыг барагдуулах зөвлөмжөө тодорхой болгохын тулд хувь тавьж өгч байгаа. Энэ жил ямар ч байсан 20 хувийг нь та нар зайлшгүй барагдуул, дараа жил 20 ч гэдэг юм уу ингээд боломжит хувилбарыг нь тооцоолж байгаад ингэж энэ албан шаардлагуудыг өгөөд ажиллаж байгаа. Эрх хүлээн авагч гэдэг одоо энэ албан тушаалтанд бол Төрийн аудитын байгууллагаас хариуцлага тооцох албан шаардлага өгөх, эрх зүйн зохицуулалт байхгүй байгаад байгаа.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд Анар гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Анар гишүүн 2024, 2025 оны төсвийг тусад нь харж үзэх хэрэгтэй шүү. 2025 оны төсөв дээр эхний нэг удаа л тодотгол хийх гэж байна. 2024 оны төсөвтөө тодотгол хийсэн ч 2024 оны гүйцэтгэлийг ярьж байна. Гүйцэтгэл нь сайжирч гарсан байгаа төсвийн тэнцэл нь. Энэ удаа яах аргагүй биднээс шалтгаалахгүй гадаад нөхцөл байдлаас болж манай гол түүхий эдүүдийн өндөр савлагаа үүсэж байгаа. Бид хэд хөгжиж байгаа орны хувьд дээрээс нь уул уурхайн эдийн засагтай улс орны хувьд иймэрхүү эрсдэл бидэнд энэ сүүлийн жилүүдэд байнга л тулгарч байна. Орлого өсөлттэй үед тэнцлүүд сайжирч гарсан. 2022, 2023 онд. Тэр цаг хугацааг бас харах хэрэгтэй. Тэр үед тодотгоод нэмээд зараагүй шүү дээ. Одоо яалт ч байхгүй ингээд орлого энэ чинь 30, 40 хувиар ингэж буурч байгаа учраас бид яах аргагүй энэ нөхцөл байдалтайгаа уялдуулж тодотгол хийхээс өөр арга байхгүй.

Жилийн төсөвт 4 удаа тодотгол хийж байгаа гэж ингэж зүг чиггүй баримжаагүй яримааргүй байна. 2024 оны гүйцэтгэлээ ярьж байна. Энэ чинь тусдаа төсөв. Одоо бид нар 2025 оныхоо төсөв дээр тодотгол хийж байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болоод Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу? Хосбаяр гишүүнээр тасалъя. Эрдэнэболд гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Монголын энэ төрийн шийдвэр гаргаж байгаа бодлого боловсруулах энэ шийдвэр гаргаж байгаа шийдвэр гаргалтын тэр процесст энэ дата бэйс нэг байх их чухал байгаад байгаа юм. Өнгөрсөн намар орон нутгийн сонгууль дээр ч гэсэн ингээд аудит СЕХ, тэгээд дээрээс нь 4, 5 байгууллагуудын хоорондох мэдээллийн зөрчилтэйгөөс болоод хэдэн мянган хүнд зөрчлийн хэрэг үүсэх түвшинд оччихсон Хүний эрхийн дэд хороон дээр асуудал нь ирж байсан. Тэр төр дотооддоо нөгөө мэдээллээ 1 мөр ойлгодог байх долгион тааруулах чинь өөрөө аягүй их бүтээмжийн асуудал. Нөгөө талдаа бас сая Жавхлан сайд хэлж байна шүү дээ. Ингээд салбар салбараа хэдүүлээ хамгаалаад байж болохгүй. Бид бас ингээд хэмжээ хязгаартай төсвийг яаж мэргэн шийдэх вэ гэдгийг бодож үзээч гэж зөвлөө

гэж байгаа юм. Бид нарын энэ шийдвэр гаргаж байгаа процесст бүгдээрээ л ил тод ойлгомжтой байх ёстой. Тэр 50 тэрбум төгрөгийг би анх удаа сонсож байна.

Тэрнээс дийлэнх нь Онцгой байдал руу явж байгаа юм байна гэж ойлголоо. Тэгэхээр ер нь энд Сангийн сайддаа ч, Сангийн яамандаа ч амар. Байгууллагууддаа ч амар байх нэг боломж нь юу вэ гэхээрээ бид тэр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа энэ хэр зэрэг энэ төсөв маань нийцэж байгаа юм бэ гэдэг прайвिति лист буюу тэргүүн эрэмбийг эрэмбэлж сурах л ёстой болчихоод байгаа байхгүй юу. Хууль дээрээ энэ гаргалгаа нь байгаа хэрнээсээ хэрэгжилт нь байхгүй. Тийм учраас яг Магнайсүрэн дарга 5 сарын 13-ны өдөр ажлаа аваад та яг 50 хонож хонож байна мөн үү? Их Хурлаас шийдвэрээ аваад 54 хонож байна 55 хонож байна. Тэгэхээр одоо энэ дээр их яаралтай ажилламаар байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ дээр аудитын газраас энэ дээр саналаа ирүүлмээр байгаад байгаа байхгүй юу. Тэр үнэлгээг яаж хийх вэ гэдэг үнэлгээг ирүүлчихнэ.

Тэгэх юм бол нөгөө салбар салбараа хамгаалаад байгаа асуудал биш. Ерөөсөө Монгол Улсын хувьд хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх амь нас зөрчигдөөд байгаа зүйл дээр ямар хэмжээний төсвийг яаж хийвэл зөв бэ гэдэг симуляцыг гаргаж ирнэ гэсэн үг. Төсөөтэй аргачлалын судалгаа гаргаж ирнэ гэсэн үг.

Жишээлбэл Ариунбуян генералын хэлээд байгаа 800, 900 тэрбум төгрөгөөс эхний ээлжид тэчнээн тэрбум төгрөгийг зайлшгүй оруулж байж энэний үр дүн дээр тийм симуляц эдийн засгийн загварчлал болон аюулгүй байдлын загварчлал нь гарч ирнэ гэсэн үг. Ингэчих юм бол бид нар хэн хэндээ амар байхгүй юу. Нөгөөдүүл нь нэг нь танах гээд үзээд байдаг, нөгөөдүүл нь тануулахгүй гээд байдаг. Тэгээд энүүхэндээ ярихад бол лобби хийгээд тал тал гүйгээд байдаг. Тэгээд хэн сайн лоббидсон нь юмаа оруулах гээд байгаа ч юм шиг энэ гажиг тогтолцоог бид нар бас ингээд өөрчлөх зайлшгүй шаардлага байгаад байгаа юм.

Тэгэхгүй болохоор ингээд сайд болсон хүмүүс нь салбарынхаа юмыг авч гарах гэж аягүй хэцүү. Тэгээд Сангийн сайд нь болохоор харамлаад суугаад байгаа биш шүү дээ энэ чинь Монгол Улсын татвар төлөгчдийн мөнгийг яаж хүргэх вэ л гэдэг юм бодож байна. Тэгээд нэг нэгэндээ муу субъектив харилцааны хувьд аягүй зөрчилтэй нөхдүүд болчихсон. Энэ нь эргээд улс төржилт болоод гараад байдаг, популизм болоод гараад байдаг. Тэгээд цаашдаа энэ нь цаашлаад засаг төр ганхах хэн нэгэн хүн хариуцлага тооцох хэмжээний үр дүнд хүрчхээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ мэдээллийн нэг цонхоор харах шийдвэр гаргалт буюу түүний эрэмбийг тогтоох дээр маш их чухал асуудалтай байгаад байгаа юм. Тэгээд энийг би Магнайсүрэн даргыг яг томилогдоход нь онцгойлж хүссэн. Энэ талаар хэдүүлээ бас уулзалт хийгээд цаашдаа энийг аягүй тодорхой болгомоор байна. Энэ бол яг одоогийн байгаа хуулийнхаа гарц дээр ҮАБЗ энэ дээр юу гаргах ёстой? Бямбажаргал даргын ахалж байгаа тэр институт энэ дээр үнэлгээний ингээд журам гаргах ёстой. Энэ дээр нь аудит өөрөө саналаа өгөх ёстой. Энийг маш яаралтай хийж байж цаашаагаа маш олон төрлийн буруу ойлголт, маш олон төрлийн эрэмбийн асуудал. Цаашаа энэ чинь зөвхөн ингээд танай байгууллагын үйл ажиллагаанаас гадна Монгол Улсын төрийн шийдвэр гаргалт илүү мэргэн байх, ухаалаг байх, амьдралд нийцсэн байх, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан байх дээр онцгой жин дарна аа.

Тэгэхээр Магнайсүрэн дарга аудитын газрынхан энэ дээр маш сайн анхаарч ажиллаасай гэж хүсье ээ. Тэгэх юм бол маш олон ирээдүйн улс төржилт хэрүүлээс бид урьдчилан сэргийлж зөв зам руугаа орох боломжтой л гэсэн санаа хэлье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хосбаяр гишүүн үг хэлнэ. Хосбаяр гишүүний микрофоныг өгье.

Г.Хосбаяр: Түрүүн би Батлан хамгаалахын сайдаас тэр нөгөө Өвөрхангайн 256 дугаар ангийн хөрөнгө оруулалтыг асуусан. Тэгээд андуурчих шиг л боллоо. Та ямар ч байсан энэ 2024, 2025 оны хөрөнгө оруулалт дээр тийм Өвөрхангайн 256 дугаар ангитай холбоотой конторын барилгатай холбоотой хөрөнгө оруулалт байхгүй байгаа.

Тэгээд үүнийг та бас нэг анхааралдаа аваарай.

Хоёрдугаарт нь энэ бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын зураг төсөл ТЭЗҮ боловсруулах гээд улсын хэмжээнд 60 тэрбум төгрөг тавигдсан байгаа. 2024 оны төсвийн тодотголоор. Тэгээд энийг болохтойгоо зэрэг Жавхлан сайд ингээд 100 хувийн гүйцэтгэлтэй гэхихсэн байна л даа. Энэ орж ирсэн бичиг баримт дээр. Энэ миний мэдэж байгаагаар жишээлбэл манай бүсэд оногдсон 10 тэрбум төгрөг ашиглагдаагүй. Сая 5 сарын 31-ээр зураг төсөл тендер зарлагдсан байсан юмнууд нь бүгд хүчингүй болоод ингээд компани шалгарчихсан мөртөө гэрээ байгуулагдаагүй. Тэгээд энийг ямар учраас ингэж 100 хувийн гүйцэтгэлтэй гэж оруулж ирж байгаа юм бол? Энэ дээрээ нэг бас нэг тодруулга өгөөрэй. Тэгэхгүй бол уг нь энийг чинь ноднин намар төсвийн тодотгол батлахад их дэмжиж баталсан шүү дээ. 6 бүсэд 10, 10 тэрбум төгрөг. Энэ мөнгөөр яг бүсийн хэмжээний төслийн ТЭЗҮ-ийг боловсруулна гээд. Гэтэл одоо энийг ингээд хойшлуулсаар байгаад ингээд сая 5 сарын 31-ээр хуулийн хугацаа дууссан гээд ингээд орхисон. Гэтэл энэ дээр ингээд гүйцэтгэл дээрээ 100 хувь гэж орж ирж байна шүү. Үүн дээр нь би бас заавал тайлбар авна. Энэ Сангийн яамныхнаас тэгэхгүй бол энэ манай бусад оногдсон мөнгө ерөөсөө ашиглагдаагүй шүү.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 онд төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг бас Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэхээр байгаа.

Хосбаяр гишүүн та танилцуулчих уу? Тэгье.

15.20 цаг

Ингээд дараагийн асуудалдаа орцгооё.

Зургаа дахь асуудал.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад оролцож байгаа албан тушаалтнууд хэвээрээ.

Ингээд уг хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Таныг микрофонд урьж байна. Сангийн сайдын микрофон.

Б.Жавхлан: Баярлалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүссэн үүсээд буй сорилт бэрхшээлийн Монгол Улсын эдийн засгийн нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 онд төсвийн тодотголын төслийг боловсруулж 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн.

Эдийн засгийн сорилт хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс тусгай үр ашигтай онцгой чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримталлаа. Энэ хүрээнд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлын бүх хөтөлбөр арга хэмжээг зогсооно.

Үүнд:

Цомхон бүтээмжтэй, төртэй байх хүрээнд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо. Мөн төсвийн байгууллагын тээвэр, шатахуун, дотоод албан томилолт, хичээл, үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолт зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж техникийн зардал төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасын зардал байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож холбогдох өөрчлөлтийг тодотголын төсөлд тусгалаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд харьяалагддаг Батлан хамгаалахын сайдын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 244 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 9.6 тэрбум төгрөг, нийт 94.3 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн. Нийт урсгал зардлын буурсан дүнгийн 31.3 хувь буюу 7.8 тэрбум төгрөгийг багаж хэрэгсэл тавилга худалдан авах зардал, урсгал зардлын зардал, салбарын орон тоог 9 хувиар бууруулахтай холбогдуулан 30.6 хувь буюу 7.6 тэрбум төгрөгийг цалин хөлсний зардал эзэлж эзэлж байна аа. Шадар сайдын багцын 2025 оны батлагдсан төсвөөс хөрөнгийн зардлыг 5.9 тэрбум төгрөг урсгал зардлыг 26.3 тэрбум төгрөгөөр буюу 32.2 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн нь нийт зардлын 8.3 хувь байна.

Салбарын төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус салбарын цалингийн санг 10.3 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн.

Гадаад харилцааны сайдын багцын 2025 оны батлагдсан төсвөөс эдгээр бодлогын хүрээнд урсгал зардал 8.5 тэрбум төгрөгөөр, зардал 1.7 тэрбум төгрөгөөр нийт 10.2 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн болно оо.

Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 47 орон тоогоор бууруулж 728 орон тоотой байхаар тооцлоо.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцаас Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах арга хэмжээний зардал 9.6 тэрбум төгрөгийг гадаад харилцааны сайдын багцад шилжүүлсэн.

ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргын багцын төсвийн 2025 онд батлагдсан төсвөөс урсгал зардал 0.7 тэрбум төгрөг, нийт 0.7 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөлөө.

Тус салбарын төрийн албан хаагчийн тоо 9 хувиар буюу 8 орон тоогоор бууруулж 90 орон тоотой байхаар тооцлоо. Ийнхүү 2025 онд төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856 тэрбум төгрөгөөр бууруулж 31 их наяд 575.1 тэрбум төгрөгт хүргэж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувьтай алдагдалтай болж байна аа.

Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ингээд төсвийн тодотгол болоод холбогдох хуулийн төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол улсын ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн дарга танилцуулна. 3 номерын микрофон өгье.

С.Магнайсүрэн: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 25-ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх, аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 3 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 7 тэрбум төгрөгөөр, зарлагыг 35.8 тэрбум төгрөг тус тус бууруулахаар төлөвлөжээ.

Байнгын хороо энэхүү төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байна.

Үүнд:

Төрийн албан хаагчдын тоог чиг үүргийн давхардал ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийлгүйгээр нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй. Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа орон тоонд зохицуулалт хийх боломж олгох асуудлыг судалж үзэх.

Хоёрт нь төсвийн тодотголтой хамт Улсын Их хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан. Энэ нь чиг үүргийн судалгааг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсгэх болзошгүй эрсдэл байгааг анхаарч үзэх.

Гуравт нь төсвийн ерөнхийлөн захирагчид харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад Төрийн албаны тухай хуульд заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөний нэг удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг олох шаардлагатай байна аа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Монгол улсын ерөнхий аудиторт баярлалаа.

Ингээд төсвийн тодотголын төслүүд болоод аудитын дүгнэлттэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Та буруу кноп дарсан байна. Эрдэнэболд гишүүнээр тасалъя. Батсүмбэрэл гишүүн асуулт асууна. Батсүмбэрэл гишүүний микрофоныг өгье.

Н.Батсүмбэрэл: Энэ дээр нөгөө онцгой байдлаас асууя.

Тэгээд дээр өмнө нь бид нар ярьж байсан төсвийн ерөнхий хүрээнд энэ онцгой байдлын албан хаагч нарын хүрэлцээ хэр байгаа юм. Тэгээд нөгөө төрийн албан хаагч нарыг 9 хувь хэмнэнэ гээд байгаа. Тэр дотор нөгөө гал унтраадаг хүн авардаг, гал устай нүүр тулдаг, шөнө өдөргүй явдаг тангараг өргөсөн албан хаагчдаа хэмнэчхэж байна уу яаж байна. Энэ асуудал яг хаанаа явж байгаа юм. Эдийн засгийн яам, Сангийн яам энэ өмнөх хуралдаанууд дээр уг нь тэнд оруулахгүй л гээд яриад байсан. Тэрэнд юу ямар байдалтай явж байгаа вэ? Төсвийн тодотгол дээр онцгой байдлын байгууллагын албан хаагчдын тоног хэрэгсэл, хангамж, техник тоног төхөөрөмжийн байдлыг яаж үзэж байгаа вэ? Одоо энэ чинь их хэмжээний түймэр гараад байна гээд л бүгд л шогшроод л, зарим гишүүн сайд нар нь очиж селфи хийгээд л яваад байгаа. Тэгээд бодит амьдрал дээрээ селфинээс илүү энд мөнгө төгрөгийг нь тавьж өгч чадаж байна уу, чадахгүй байна уу?

Тэгээд нөгөө урдаас нь айгдах биш ядаж энэ төсвийг нь танахгүй байх хэрэгтэй шүү дээ. Өдөр шөнөгүй ажиллаж байгаа албан хаагчдынхаа. Энэ дээр ОБЕГ, Сангийн яам? Эдийн засгийн яам нэг хариулж өгөөч.

Хоёрдугаарт нь тэр га ГХЯ-ны дипломат албан хаагч нар ялангуяа гадаад улсад ажилладаг албан хаагч нар энэ ханшийн зөрүүн дээр цалингийн хувьд маш хүнд байдалтай болдог юм байна лээ. Монгол төгрөгөөр төсөв цалинг нь бодчихдог.

Ханшийн зөрөөнд ороод тэндээ түрээсийн төлбөр нь хүндэрдэг. Цалин мөнгө нь хүндэрдэг. Бодит байдал дээр хүмүүс ажиллаж амьдарч байгаа. Тэгэхээр энэ байдлыг ер нь яаж тооцож байгаа юм. Цаашдаа тэр энэ асуудлыг хэрхэн авч үзэх юм. Гадаад харилцааны алба хаагчдыг тусгай албаны субъектэд оруулж тооцох цалинг нь өөр байдлаар тооцох гээд энэ асуудлууд яригдаад байсан. Энэ асуудлыг 2025 оны төсөв дээр ер нь яаж тооцож үзэж байгаа вэ? Бидний газар нутгийн хувьд том хэрнээ хүн ам цөөтэй улс орны хувьд энэ дэлхийн дэг журам өөрчлөгдөж байгаа геополитикийн нөхцөлд олон тулгуур дипломат харилцааны бодлогоо тусгаар тогтнолоо хамгаална. Эдийн засгаа хөгжүүлнэ гэж ярьдаг.

Үүнийгээ бодит амьдрал дээр хэрэгжүүлмээр байгаа юм. Тэгээд энэ дээр ГХЯ нь өөрөө хэр санаачилга гаргаж байна. Энэ дээр Сангийн яам хэр мөнгө тавьж өгч байгаа юм? Өөрсдөө гаднаас зочин гийчин авна гадаад улстай хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ шинэ тутам хамтын ажиллагааг тэтгэнэ, эдийн засгийн том супер харилцаа бий болгоно гэххээд энэ гадаад харилцаан дээрээ мөнгө татаад байгаа юм биш биз дээ. Энийг асууя.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

5 номер ОБЕГ-ын дарга Ариунбуян дарга, дараа нь Сангийн яам.

Г.Ариунбуян: ОБЕГ-ын дарга хошууч, генерал Ариунбуян Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Улс орны эдийн засагт нөлөөлж байгаа энэ улсын төсвийн орлогын бүрдүүлэлт буурч байгаатай холбоотой Засгийн газраас барьж байгаа энэ 9 хувийн

цомхотголын асуудлыг бид нар маш сайн ойлгож байгаа. Энэ тал дээр бид нар Сангийн яамтайгаа бас ярьсан. Тэгээд төсөв тооцоогоо бас нягталсан.

Ер нь 500 орчим алба хаагч энэ цомхотголд өртөхөөр байгаа. Тэгээд аль болохоор захиргааны ажил хийдэг ийм түвшний тэгээд зарим нэг ажлын байрны шинжилгээг дотооддоо хийж, чиг үүргийн давхцал дээр бас хяналт тавих замаар энэ бодлогыг хэрэгжүүлнэ гэдэг ийм л байр суурьтай. Тэгээд дээр нь бол энэ дээр тодорхой тооны яг албан үүргээ гүйцэтгэж байгаа аврагч гал сөнөөгч гэдэг юм уу ийм бага тушаалын бас хүмүүс бас энэ тоонд бас орж байгаа юм. Тодорхой хувиар орохоос ч өөр аргагүй ийм нөхцөл байдалтай байна аа.

Хоёрдугаарт нь энэ төсвийн тодотгол дээр манай хэд энэ жилийн оруулж байгаа хөрөнгө оруулалтаар хасагдсан зүйл байхгүй. Харин ч энэ нөхцөл байдалтай холбогдуулаад Сангийн яамнаас бас Засгийн газрын нөөц сангаас сая өнгөрсөн 1 сарын хугацаанд 5 орчим тэрбум төгрөгийн асуудал шийдэгдсэн. Маргааш бас Засгийн газрын хуралдаанаар мөн тодорхой төсвийн асуудлыг одоо оруулж энэ гал унтраах техник тоног төхөөрөмж, автомашины асуудлыг шийдвэрлэхээр ингээд ажиллаж байна аа.

Г.Тэмүүлэн: Сангийн яам хариулах уу? 6 номер. Сангийн яам.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя.

Өмнө нь нөгөө улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө хэлэлцэж байх үеэр Батсүмбэрэл гишүүн бол яг энэ Онцгой байдлын албан хаагчдыг бууруулах боломжгүй. Энэ хүмүүсийг энэ цомхотголоос тусад нь авч үзэх ёстой ангид байх ёстой гэдэг байдлаар санал хэлж байсан. Энэ санал, дүгнэлт чуулганы хуралдаанаар бас санал, дүгнэлт дээр орсон байгаа. Хэдийгээр тийм боловч яг одоо батлагдсан энэ 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөгөөр нийт төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар буюу 20.1 мянгаар ингээд бууруулахаар заачихсан. Тэр дундаа төрийн тусгай албан хаагчдыг 4-ний 1-ээр бууруулна буюу 25 хувиар бууруулна гэсэн нэг ийм заалт орчхоод байгаа юм аа. Энэ маш хүнд тусаж байгаа.

Ялангуяа бол яг энэ Аюулгүй байдлын байнгын хороон дээр орж байгаа батлан хамгаалах болон онцгой байдлын салбарын хувьд бол орон тоо нь нийт хэмжээгээр нууц байдаг. Тэгэхээр бид бол хянахдаа зөвхөн ажиллаж байгаа хүний тоогоор тоог нь хяначихдаг учраас яах аргагүй сул орон тоо гэсэн ойлголт байхгүй. Шууд орон тоо нь буурахаар эрсдэлтэй харагдаж байгаа.

Гэхдээ бол энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй бид нар нийцүүлээд орж ирсэн байгаа. Ер нь цаашдаа яах ёстой вэ гэдэг дээр гишүүний хэлж байгаатай санал нэг байна.

Онцгой байдлын байгууллагатай Сангийн яамны хувьд хамтарч ажиллаад бид төсвийн процессыг энэ жил энэ цагалбараас хамаагүй эрт эхлүүлсэн байгаа. Сангийн сайдын болон Шадар сайдын хамтарсан ийм ажлын хэсэг гараад хэрэгцээ шаардлага дээр ажиллаж байна аа.

Одоогийн байдлаар эхний санал, дүгнэлтээр бол нийтдээ 8 мянга орчим орон тоо яг жинхэнэ бодит стандартаар ажиллая гэх юм бол дутагдалтай байна гэдэг ийм

санал, дүгнэлт гарч байна. Мөн техник хэрэгсэл болон аврах хувцас хэрэгслийн хангамжийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг гаргаж ирж байна. Гэхдээ бид нар энэ улс орныхоо одоогийн нөхцөл байдалдаа тохируулаад эхний ээлжид гадаадын зээл тусламжаар энэ томоохон хэмжээний тоног төхөөрөмжийг ноу хау шингэсэн эдгээр тоног төхөөрөмжийг бол өмнө нь Монголд ашиглаж байгаа гэдэг агуулгаар нь хангах ийм зорилго зорилт тавиад хамтарсан байдлаар ажиллаад явж байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Эрдэнэболд гишүүн гадаад яамнаас байгаа. Гадаад яам хүлээж байгаарай, түр байж байгаарай. Батсүмбэрэл гишүүний асуултад Батцэцэг сайд Сангийн яам хариулах уу? Гадаад яамтай холбоотой асуулт асуусан. 6 номер Санжаадорж.

М.Санжаадорж: Гадаад яамны хувьд бол бас төсвийн тодотголоор бол яг адилхан зарчим бариад орон тоо болон бусад зардлуудыг бид бас бууруулахаар орж ирсэн байгаа. Энэ жилийн хувьд бол төсвийн тодотголоор ингэж орж ирээд явахаас өөр аргагүй болж байна. Нөгөө талдаа ирэх жилийн төсвийн төсөл дээр бас бид энэ өр төлбөр үүсэх зарим салбарууд дээр үүсэж байгааг зөвхөн Гадаад яам гэхгүйгээр бусад бүх салбарууд дээр бас дүгнэлт гаргах мөн энэ буурч байгаа энэ орон тоотой холбоотойгоор үүссэн тэр нөхцөл байдал чиг үүргийн судалгааг 9 сарын 1 гэхэд бид ирэх жилийн төсвийг өргөн барихад бол дүгнэлт гарчихна гэж найдаж байгаа. Энэ судалгааг Эдийн засгийн хөгжлийн яамнаас хийж оруулж ирнэ гэж бид тооцож байгаа. Хэрвээ орж ирсэн тохиолд мөн энэ судалгаан дээр тааруулаад ер нь төрийн албан хаагчдын хувьд болон байгууллагын хувьд онцлогтойгоор яг саяын аудитын байгууллагын хэлж байгаа тийм байдлаар бас санал, дүгнэлт нь өөрөө төсвийн төсөл дээр тусаад орж ирнэ гэж тийм хүлээлттэй байж болно. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Үгүй яах вэ ер нь юу байгаа юм л даа. Бид нар нэг 2 зүйлийг нэг сайн ойлгомоор байгаад байгаа юм. Нэг талдаа ингээд хэмнэх асуудал яриад байдаг. Нөгөө талдаа нэг хэмнэж болохгүй бас нэг зарим нэг асуудлууд бий. Тэр гал түймэртэй улаан гараараа тэмцэж байгаа алба хаагч нар, өвлийн хүйтэнд цас мөстэй ноцолдож байгаа алба хаагч нарыг хэмнэж яах гээд байгаа юм. Тэдний амьдралд тэглээ тус нэмэр болж байгаа юм уу. Тэгээд цалинг нь хэмнэх гээд байдаг, өөрсдийг нь хэмнэх гээд байдаг. Гадаад оронд улс орноо төлөөлөөд ажиллаж байгаа тэр гадаад дипломат ажилтан албан хаагчдын цалин цавууг бусад орнуудтай харьцуулахад ядуу дорой харагдуулах ямар хэрэгтэй юм. Тэгээд энийгээ л анхаараач гэж Сангийн яамны энэ ажил хариуцсан нөхдүүд хэлээд байгаа юм шүү дээ.

Тэгэхээр иргэдийг дэмжих туслах сан гэж байна. Тэрийг хүртэл нэммээр л юм байна лээ. Бодит амьдрал дээрээ. Та бидэн чинь ингээд л арай өөр байдлаар хараад байдаг. Тэгээд ийм тулчихсан энэ асуудлуудаа л анхаарвал яасан юм.

Г.Тэмүүлэн: Санжаадорж нэмж хариулах уу? Санал гэж ойлголоо саяынхыг. Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Асуулт гэхээсээ илүүтэйгээр ийм байгаа юм. Манай энэ Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны бас энэ хурал болж байгаа. Тэгэхээр бид нарын энэ шалгуур бол яг аюулгүй байдалтай холбоотой.

Тус Байнгын хорооны авч үзэх хамаарах асуудлын хүрээнд л энэ асуудлууд явагдаж байгаа юм. Төсөвтэй холбоотой асуудал.

Тэгэхээр яасан гэхээр нөгөө Эгийн голын цахилгаан станц гээд л баахан яриад байсан маань олон жил гацаж гацаж байгаад явжээ. Тэгээд энэ дээр Монгол Орос чинь тал талаасаа ингээд мөнгө гаргаад явах байсан чинь тэр төсөв нь жишээлбэл 1 тэрбум төгрөг хасагдсан юм байна. Хилийн усны хэлэлцээрийн мөнгө хасагдсан. Яах вэ томъёог нь ингээд аваад үзэхлээрээ ойн газар бол 46 тэрбум төгрөг, ус цаг уурын орчны шинжилгээний газар нэг 60 тэрбум төгрөг, усны агентлаг нэг 5 тэрбум гаран төгрөгтэй. Тэрнээс урсгал зардал 24 тэрбум төгрөг нь үлдээд 2.9 тэрбум нь хасагдсан. Тэр дотор чинь болохоор энэ Эгийн голын хилийн усны хэлэлцээрийн нөгөө Хэрлэн тооноттой холбоотой нөгөө стратегийн буюу 14 мега төсөлтэй холбоотой төсвүүд хасагдаж. Тэгээд яах вэ энийг чинь бас нөгөө бид нарын бас аюулгүй байдалтай холбоотой сэдэв учраас одоо байгаа дүрмийн дагуу энэ чинь нөгөө нэг төсвөөс дотор нь гүйлгэж авах гээд байна шүү дээ. Тэгэнгүүт яах вэ энэ нэг ой юм уу, Усны ус, цаг уурын газраас юм уу гэдэг Тэмүүлэн дарга аа яг энийг нь би эргээд асууж байна л даа.

Тэгээд энийг яг энэ холбогдох нөгөө төрийн захиргааны төв байгууллага яамныхаа сайдтай ярьж байгаад ажлын хэсэгт энийг санал болгож оруулъя гэж бодлоо.

Ажлын хэсэг санал байдлаар оруулаад ингээд судлаад үзье гэдэг талаас нь яах вэ протоколд энэ саналыг бас хэлмээр байгаа юм. Яагаад гэхлээр түрүүний л нөгөө ярьсан эрэмбийн асуудал болчихоод байгаа байхгүй юу Магнайсүрэн дарга аа.

Одоо яг нөгөө сүйхээтэй нэг нь төсвөө авч үлдэх гэж байгаа ч юм шиг үгүйнүүд нь ингээд гээгдэх гээд байгаа юм шиг юм болчихоод байгаа юм. Тэгээд нөгөө энэ Сангийн сайд руугаа болохоор хасчихлаа гээд байдаг. Энэ хүн чинь субъектив хасалт хийхгүй байгаа шүү дээ. Яагаад гэхээр ингээд тана тана гэж бүгдээрээ улс төр хийж шахчхаад, хасаж танасных нь дараагаар болохоор чи таначихлаа гэдэг байдлаар дайраад байж болохгүй гэсэн санал.

Тэгэхээрээ л түрүүний саяын энэ Батсүмбэрэл гишүүний хэлээд байгаа ч тэр ер нь энэ зарчим чинь ер нь нөгөө л эрэмбийн асуудал. Жавхлан сайд тийм биз дээ? Энэ эрэмбэ нь тодорхой болоод тэр үндэсний аюулгүй байдлын 6 шалгуурт нийцүүлээд энийг хийчих юм хэн хэндээ амар. Төрийн бодлого чинь тодорхой болчихвол хэн хэндээ л амар болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд энийг ер нь юмны учир, сумны занги Магнайсүрэн дарга тан дээр л оччихоод байгаа шүү.

Та манлайлалтай байж байж энийг хэдий чинээ хурдан хийж чадна төдий чинээ учиг хурдан тайлагдана гэсэн үг. Сая одоо ингээд л юу нь чухал, юу нь чухал биш юм бэ гэхээр бас хэцүү. Улс төрчдийн яамнаас энэ чинь гарахад аймаар хэцүү болчихоод байгаа байхгүй юу. Энэ чинь тойргоо сонгогдсон гишүүд байгаад байдаг. Тэгээд энийг чинь бас шууд хүйтэн логигоор хэлэхэд хэцүү болчихоод байдаг. Тэгэхээр дараа дараагийн юмнууд дээр л энийг та хурдан гаргаж өгөөрэй л гэдэг дахиад санал хэлчихье. Гэх мэт ингээд л бид нар руу ингээд л баахан зовлон ярьсан хүмүүс байгаад байдаг.

Алинд нь үгүй, алинд нь тийм гэж хэлэх нь бид нарын мэдэх мэдэхгүй юм болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас та анхаараарай л гэж хэлье.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Бас Эрдэнэболд гишүүн эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотойгоор төсөл хөтөлбөрүүдийн тодорхой санхүүжилт зардлуудтай холбоотойгоор тодорхой саналыг хэлж байна. Холбогдох байгууллагууд бас энийг анхаарч ажиллаарай.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Надад нэг тодруулах зүйл нь Сангийн яамнаас хариулах уу? Ер нь энэ удаагийн төсвийн тодотголыг бол ерөөсөө хэмнэлтийн төсөв гэж байгаа. Тодорхой хэмнэлт хийх бас төсвийн тодотгол гэж Засгийн газрын тэргүүн өөрөө бас нэрлэж байгаа.

Тэгэхээр энэн дээр ямар нэг байдлаар өмнөх онд оруулж ирж батлуулсан төсөв дээрээс зардал нь ямар нэг байдлаар нэмэгдэж байгаа байгууллагууд байна уу? Төсвийн ерөнхийлөн захирагч нар байна уу?

Хэрэв тийм байгууллагууд байгаа бол ямар үндэслэлээр хэчнээн байгууллага нэмэгдэж байгаа юм бэ? Манай Байнгын хороонд хамаарах 3 яамнаас бол үндсэндээ байгууллагаас Гадаад харилцааны сайд дээр 5.3 тэрбум төгрөгөөр өмнөх 2025 оны төсөв батлагдсан төсвөөсөө 5.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа харагдаж байсан. Энэ дээр нэг тайлбар хэлээч гэсэн асуулт байна. Энэ дээр хариулъя хэн хариулах вэ? Санжаадорж 6 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Энэ удаагийн төсвийн тодотголоор шинээр 3 төрлийн зардал нэмэгдэж оруулж ирж байгаа. Эхнийх нь Тэц 3-тай холбоотой зардал, мөн эрчим хүчний энэ татаастай холбоотой багц зардал эрчим хүчтэй холбоотой гэсэн үг.

Хоёр дахь нь бол Копын хурлыг зохион байгуулахтай холбоотой зардлыг шинээр тусгаж орж ирсэн.

Гурав дахь нь Засгийн газрын нөөц санг нэмэгдүүлэхтэй холбоотой зардал нэмж орж ирсэн байгаа. Бусдаар өөр зардал аль нэг төсвийн ерөнхийлөн захирагч дээр нийт дүнгээр нэмэгдээгүй.

Гадаад харилцааны сайдын зардал дээр нэмэгдсэн зардал энэ өөрөө бол Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд дээр тусаж байсан. Энэ зардал нь чиг үүрэг нь шилжиж байгаатай холбоотойгоор зардалд нь шилжсэн байгаа. Мөн одоо бусад шилжсэн зардлууд гэх юм бол Сангийн сайд дээр хилийн асуудал шилжиж очиж байгаатай холбоотойгоор боомтын асуудал шилжиж очиж байгаатай холбоотойгоор бол боомттой холбоотой, боомтын захиргаа гэдэг байгууллага шилжсэн байгаа.

Мөн дээрээс нь хяналт хэрэгжүүлэх сайдын чиг үүргийг Эдийн засгийн хөгжлийн яам руу шилжүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар Эдийн засгийн хөгжлийн яаманд очсон. Энэ зардлууд зүгээр

шилжсэн гэж хэлж болно. 20 минутын хотын сайдын багц бол БХБЯ руу шилжсэн байгаа.

Төсвийг байгууллага болгоноор нь харах юм бол нийт төсвийн эрхлэн захирагчаар нэмэгдэж байгаа ийм төсвийн эрхлэн захирагч байхгүй. Анх төсөв батлагдахдаа бөөн дүнгээр жишээ нь ХЗБХ-н дээрээс ШЕЗ бөөн дүнгээрээ батлагдаж орж ирчхээд тэгээд 1 дүгээр сар дээр хуваариар бусад дүүрэг аймгийнх нь шүүхүүддээ хуваагдаад батлагддаг. Энэ бол юу гэдэг юм байгууллага хоорондын зохицуулалтын хүрээнд нэмэгдэж байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх нь байгаа. Төсвийн хуулиар нэмэгдэж байгаа юм шиг харагдаж байгаа. Гэхдээ нийт дүнгээр бол бүх төсвийн ерөнхийлөн захирагчийн дүн барина. Энүүгээр нэмэгдэж байгаа зардал гарч ирэхгүй ээ.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ингээд Байнгын хорооны гишүүд эрхлэх асуудлын хүрээнд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу? Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Батсүмбэрэл гишүүн үг хэлнэ.

Н.Батсүмбэрэл: Энэ онцгой байдлыг онцгойлж анхаарах ёстой юм гэдгийг Сангийн сайд Сангийн яамныхандаа онцгойлон захиж хэлье ээ. Энэ чинь Жавхлан сайдын тойргийн ойн модыг хамгаалж байгаа, иргэдийн амь нас өмч хөрөнгийг хайрлан хамгаалж байгаа хүмүүс шүү Жавхлан сайд аа. Үгүй танд захиж хэлж байна аа. Тэгээд Сангийн яам энэ дээр анхаараарай.

Дараагийнх нь би үгээ хэлчих үү.

Би бас үгээ хэлчихье, үгээ хэлчихье. Тэгээд энэ ГХЯ-ны хилийн чанадад байгаа Монголчууд Монгол иргэдэд туслах сан гэж байгаа. Үүнээс энэ 600 сая төгрөг байгаад байгаа. 512 сая төгрөгийг нь хорогдуулах санал байгаад байгаа юм. Үүнийг үлдээж болохгүй юу. Энэ чинь гадаад улс оронд байгаа иргэддээ туслах тэр гадаад улс оронд байгаа иргэдээ татан авчрах бас маш олон асуудлуудыг энүүгээр шийддэг юм байна. Энэ асуудлыг арай өөр хэлбэрээр борлуулаад энэ 500 сая төгрөгийг нь үлдээхэж болохгүй юу. Ийм саналыг хэлж байна аа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны гишүүдэд гаргах зарчмын зөрүүтэй саналын томьёолол байхгүй байна.

Ингээд хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулах үүрэгтэй байгаа. Ингээд миний бие энэ асуудлыг бас Төсвийн байнгын хороонд танилцуулчихъя.

Төсвийн тодотгол болоод холбогдох хуулиудад оруулж байгаа өөрчлөлтүүдийн төслүүдийг буюу 2 дахь хэлэлцүүлгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо явуулж дууслаа.

Холбогдох албан тушаалтнууд болоод ажлын хэсгийнхэнд баярлалаа. Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье ээ.

Байнгын хорооны гишүүддээ бас баярлалаа. Идэвхтэй оролцож байгаад.

15.48 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА